

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын боловсрол

*Ерөнхий боловсролын сургуулийн 3, 4-р ангийн
багш нарт зориулсан гарын авлага*



Агуулга

Өмнөх үг	ii
Бүлэг 1 – Танилцуулга	1
Яагаад Монгол Улсад замын хөдөлгөөний аюулгүй байдал чухал болсон бэ?	4
Яагаад Улаанбаатар хотод замын хөдөлгөөний аюулгүй байдал чухал вэ?	5
Яагаад Монгол Улсад төмөр замын гарам орчмын аюулгүй байдал чухал вэ?	5
Авто замын хөдөлгөөн, төмөр зам орчмын аюулгүй байдлын боловсролыг үр дүнтэй байлгах гол түлхүүрүүд	6
Бүлэг 2 – Замын хөдөлгөөний аюулгүй байдал ба бага насны хүүхдүүд	8
Замын хөдөлгөөний аюулгүй байдал ба хүүхдүүд	8
Яагаад хүүхдүүд замын хөдөлгөөн болоод галт тэрэгний хөдөлгөөний эргэн тойронд эрсдэлтэй/эмзэг байдаг вэ?	8
Замын хөдөлгөөний эргэн тойрон дахь хүүхдүүдэд зориулсан түлхүүр алхамууд	9
Бүлэг 3 – Замын хөдөлгөөний аюулгүй байдлын боловсролын талаарх үндсэн зарчмууд	11
Бүлэг 4 – Заагдах сэдвүүд	15
Бүлэг 5 – Замын хөдөлгөөний аюулгүй байдлын голлон хүргэх мэдээлэл	16
Бүлэг 6 – Явган зорчигчийн аюулгүй байдал	17
Бүлэг 7 – Суудлын автомашинаар зорчигчийн аюулгүй байдал	26
Бүлэг 8 – Автобусаар зорчигчийн аюулгүй байдал	32
Бүлэг 9 – Мотоциклоор зорчигчийн аюулгүй байдал	36
Бүлэг 10 – Сургууль руу аюулгүй зорчих	40
Бүлэг 11 – Галт тэрэгний эргэн тойрон дахь аюулгүй байдал	44
Бүлэг 12 – Харагдахуйц байх	50
Бүлэг 13 – Замын хөдөлгөөний аюулгүй байдлын замын тэмдгүүд	53
Бүлэг 14 – Унадаг дугуйн аюулгүй байдал	54
Хавсралтууд	57
1.	59
2.	59
3.	59
4.	59
5.	59
6.	59
ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ	97

Бүлэг 1 – Танилцуулга

Энэ юуны тухай гарын авлага вэ?

Энэхүү Замын хөдөлгөөний аюулгүй байдлын боловсрол олгох багшийн гарын авлага нь Боловсрол, Шинжлэх Ухааны яамны (БШУЯ) 2018 оны 4-р сарын 6-ны өдөр гаргасан 185 тоот тушаалын дагуу "Аюулгүй амьдрах" сургалтын хөтөлбөрийн хүрээнд авто замын хөдөлгөөн, төмөр замын хөдөлгөөн орчмын аюулгүй байдлын талаар ерөнхий боловсролын сургуулийн (ЕБС) 3, 4-р ангийн багш нарт заах арга зүйг төлөвлөх, боловсруулахад туслах зорилготой.

Энэхүү гарын авлага дахь авто зам, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын хичээлийг "Хүн ба Орчин", "Хүн ба Нийгэм", "Хүн ба Байгаль" хичээлийн хөтөлбөртэй холбож үзэж болно. БШУЯ нь эдгээр хичээлийн сургалтын хөтөлбөрүүдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг боловсруулж тусгах болно.

Энэхүү гарын авлагад багш нарт зориулж хүүхдүүд яагаад замын хөдөлгөөнд, төмөр замын гарам орчимд ийм их эрсдэлтэй байдаг талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, үр дүнтэй боловсрол олгох зарчим, хичээлийг төлөвлөж бэлдэх, хичээл заахад туслах санаа, дасгал ажлын хуудсыг багтаасан болно.

Гарын авлага нь дараах мэдээллийг агуулсан болно. Үүнд:

- Хүүхдүүд яагаад замын хөдөлгөөн, төмөр замын ойр орчим амь насаа алдах эсвэл хүнд бэртэх эрсдэл өндөр байдаг вэ;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын боловсрол олгох үр дүнтэй зарчмууд;
- Хүүхдүүд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх ойлголтоо хэрхэн хөгжүүлдэг вэ;
- 3, 4-р ангийн сурагчдад (8-аас 10 хүртэлх насны) зориулсан гол агуулга ба хүргэх мэдээлэл;
- 3, 4-р ангийн сурагчдын хичээлд ашиглах дасгал ажил ба хичээлийн бүтэц;

Хэн энэ гарын авлагыг боловсруулсан бэ?

Энэхүү багшийн гарын авлагыг Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ)-тай хамтран боловсруулав.

Авто замын хөдөлгөөн, төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдалд ЕБС-ийн гүйцэтгэх үүрэг

Хүүхдийн хөгжилд эцэг эх болон ЕБС чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хүүхдүүдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцох, төмөр замын гармаар аюулгүй гарах дадалд сургах дараах чадваруудыг хөгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Замын хөдөлгөөн, төмөр замын гарам орчмын аюулгүй байдлын талаарх мэдлэг ба ойлголтыг өгөх.
- Авто замын хөдөлгөөн, төмөр замын гарам орчинд аюулгүй байх зан төлөв.
- Өөрсдийгөө аюулгүй байлгах үүргээ ухамсарлаж ойлгох.
- Төмөр зам болон зам тээврийн ослын шалтгаан, үр дагаврын талаарх мэдлэгийг олгох.
- Өөрийн аюулгүй байдлыг сайтар хангах, 12 болон түүнээс дээш настай болсон нөхцөлд бусдын аюулгүй байдалд анхаарал хандуулах.

Сургууль нь эцэг эхчүүдийн эргүүл(school police), Тээврийн цагдаагийн алба, орон нутгийн захиргаатай хамтран ажиллахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд, ингэснээр ангийн багшийн олгож буй мэдлэг, зан байдлыг бэхжүүлдэг.

Яагаад авто замын хөдөлгөөн, төмөр замын гарам орчмын аюулгүй байдлын талаар багш нар ангидаа заах нь чухал вэ?

Хүүхдүүд багш нараа үлгэрлэн дуурайдгийг эцэг эх, багш бүр мэддэг.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хичээлийн дундуур хэн нэгэн зочин биш, ангийн багш заах ёстой. Замын цагдаа, Төмөр замын цагдаа, яаралтай тусламжийн эмч зэрэг зочид ихээхэн ач холбогдолтой боловч ангийн багшийг орлож чадахгүй.

Монгол Улсын бүх хүүхдүүдэд замын хөдөлгөөн, төмөр замын гарам орчмын аюултай нөхцөл байдал ижил түвшинд тулгардаг. Тэдэнд аюулгүй байх шаардлагатай мэдлэг, хандлага, зан төлөвийг хөгжүүлэхийн тулд нэгдсэн мэдээлэл өгч, аюулгүй байдлыг сайн дураараа хэрэгжүүлдэг иргэн, жолооч болгон бэлтгэх ёстой. Ирээдүйд тэд хүүхдээ аюулгүй байлгах мэдлэг, чадвар, дадал зуршил, үнэт зүйлтэй эцэг эх болно.

**Монгол Улсад
замын
хөдөлгөөний
аюулгүй байдал
яагаад чухал
болсон бэ?**

2010-2019 оны хооронд Монгол улсад бараг 10,000 хүүхэд зам тээврийн осолд өртөж гэмтсэн эсвэл амь насаа алдсан байна.¹

Монгол улсын авто зам, замын хөдөлгөөн маш их өөрчлөгдсөн. Өнөөдөр илүү их тээврийн хэрэгсэл, илүү өргөн авто зам, зорчигч ихтэй, замын хөдөлгөөн илүү хурдацтай явагдаж байна. Бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 266,430 (2009)-аас 1,043,028 сая (2019) болж бараг дөрөв дахин нэмэгджээ.² Ачааны автомашин (330%), автобус (15%), цистерн ачааны автомашин (1,247%), чиргүүл (688%), механизм (267%), тусгай зориулалтын автомашин (117%) зэрэг хүнд даацын тээврийн хэрэгслийн тоо огцом нэмэгдсэн байна. Одоо 2009 оныхоос суудлын автомашин болон ачааны автомашины тоо дөрөв дахин, цистерн төрлийн автомашины тоо 10 дахин их байна. 2009 онд бүртгэлтэй хагас чиргүүлтэй ачааны автомашин байгаагүй бол 2019 онд 23850 болжээ.

Монгол улс нь хөдөөгийн нүүдэлчин аж амьдралтай орон юм. Гэсэн хэдий ч амьдралын хэв маяг эрс өөрчлөгдсөн. Одоо ихэнх Монголчууд Улаанбаатар хотод эсвэл хүүхдэд ээлгүй суурин газар амьдарч байна.

Хөдөө орон нутгаас Улаанбаатар хот болон бусад хот руу ирж буй эцэг эхчүүд, хүүхдүүд аюулгүй байдлаа сахих мэдлэг, чадваргүй байж болно. Гэвч бүх хүүхэд эрсдэлийг таньж мэдэх, шийдвэр гаргах, аюулгүй байдлаа өөрсдөө хамгаалах, чадвараа хэрхэн хөгжүүлэх талаар заалгах ёстой.

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний стратеги 2030 нь ард иргэдийнхээ сайн сайхны төлөө замын хөдөлгөөний аюулгүй байдалд томоохон өөрчлөлтийг авчирч байна. Хүүхэд бүр Монгол Улсад үнэт эрдэнэ юм.

¹ Эх сурвалж: Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт, 2020

² Эх сурвалж: Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт, 2020

**Улаанбаатар хотод
замын
хөдөлгөөний
аюулгүй байдал
яагаад чухал вэ?**

Монгол бол хүн амын талаас илүү хувь нь зөвхөн нэг хотдоо амьдардаг дэлхийн цөөн тооны орны нэг юм.

2030 он гэхэд Монголчуудын 50-иас дээш хувь нь Улаанбаатар хотод амьдрах төлөвтэй байна.³ Улаанбаатар хотын авто зам нь хүүхдэд ээлгүй. Өвлийн цаг уур болон агаарын бохирдлын нөхцөл байдлын улмаас үзэгдэх орчин муу, хөлдөх температур нь хүүхдэд илүү их аюул учруулж байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн тоо 76,2 дахин нэмэгдэж, 135160-аас 568866 болсон байна.

Улаанбаатар хотын 2020 оны мастер төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн хандлага нь аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьдаг:

Зорилт 1: ' Улаанбаатар аюулгүй, эрүүл, ногоон хот болно ...'

**Монгол Улсад
төмөр замын гарам
орчмын аюулгүй
байдал яагаад
чухал вэ?**

Төмөр замын тээвэр бол Монгол Улсын хүн ба ачаа тээврийн чухал хэрэгсэл юм. Хөдөө орон нутагт төмөр замын олон гарам хаалтгүй, тэмдэггүй байдаг.

³ Улаанбаатар хотын 2020 он хүртэлх мастер төлөвлөгөө. 2030 он хүртэлх хөгжлийн арга замууд - Олон нийтэд хүргэх ерөнхий тойм

Хүүхдүүд бол жижигхэн насанд хүрэгчид биш. Тэдний бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл болон нийгмийн хөгжил нь олон жилээр явагддаг. Авто зам болон төмөр зам нь хүүхдүүд амьтасаа алдах эрсдэлд өртөх эсвэл ослоос болж гэмтэж бэртэх аюултай газар юм.

12 хүртэлх насны хүүхдүүд нь:

- Бие бялдарын хувьд ихэнх нь жижигхэн, ялангуяа зогсоолд байгаа тээврийн хэрэгслүүдийн дундуур алхан гарч ирэх, галт тэрэгний урдуур гүйх үед жолооч олж харахад хүндрэлтэй.
- Насанд хүрэгчидтэй адил хэмжээнд аливаа зүйлсийг хардаггүй, сонсдоггүй. Жишээ нь тэд тээврийн хэрэгслийн эсвэл галт тэрэгний дууг сонсох магадлалтай боловч аль зүгээс энэхүү чимээ гарч байгааг хэлж чадахгүй.
- Тэдний нүдний харааны хүрээ, ялангуяа захын юмсыг харах чадвар бүрэн хөгжөөгүй байдаг.
- Санамсаргүй тааралдсан хүмүүс, амьтан, юмс үзэгдлээс болж тэдний анхаарал амархан сарнидаг, улмаар аюулгүйн дүрмээ мартдаг.
- Тэд мөн ганцхан зүйл (цүнхэндээ, гартаа барьж буй бөмбөг эсвэл зайрмаг, гар утсандаа)-д анхаарлаа бүрэн төвлөрүүлэх боломжтой тул авто замын ба галт тэрэгний хөдөлгөөнийг харах, сонсохоо мартдаг.
- Ойртон ирж буй тээврийн хэрэгслийн хурд болон зайг тооцоолж чадахгүй тул авто замыг хөндлөн гарах аюултай шийдвэрийг гаргадаг, ялангуяа тухайн авто замын зорчих хэсэг нь нэгээс олон эгнээтэй бол бүр ч аюултай.
- Тэд зам хөндлөн гүйж эсвэл замын ойролцоо тоглож эсвэл төмөр зам дээр тоглож, тээврийн хэрэгсэл, галт тэрэг ямар ч үед ирэх боломжтой гэдгийг мартаж болно.
- Хэрэв тэдэнд хоцрох гээд гүйх, замын нөгөө талд найз нь эсвэл эцэг эх нь байхыг харах, бүхимдуу байх, өөртэй нь чацуу эсвэл арай том хүүхдийн ятгалгаар эрсдэлтэй үйлдэл хийх гэх мэт гэнэтийн зүйлс тохиолдвол замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг шууд мартдаг.

Замын хөдөлгөөний эргэн тойрон дахь хүүхдүүдэд зориулсан түлхүүр алхмууд

6 хүртэлх насны хүүхэд	Сургуулийн өмнөх насны хүүхдүүд эх эцэг, цэцэрлэгийн багшаасаа хамааралтай бөгөөд тоглох, алхах, автомашин, автобус, галт тэргээр зорчих, галт тэрэгний тавцан дээр зогсох, төмөр замын гарам хөндлөн гарах зэрэгт тэдний аюулгүй байдлыг насанд хүрэгчид хангаж байдаг. Хүүхдүүд замын хөдөлгөөн, төмөр замын гарам орчмын аюулгүй байдлын дүрмийг заалгаж болно, гэхдээ дүрэм ямар учир утгатайг ойлгохгүй.
-------------------------------	---

**6, 7
настай
хүүхэд**

Хүүхдүүд 7 нас хүртлээ авто зам эсвэл галт тэрэгний хөдөлгөөнд аюулгүй зорчих ур чадвар, мэдлэггүй байдаг. Тэдний аюулгүй байдал насанд хүрэгчдээс хамааралтай бөгөөд замын хөдөлгөөн, галт тэрэг, төмөр замын ойролцоо явах бүрд гараас нь хөтөлж явах хэрэгтэй. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үүднээс насанд хүрэгчдэд 12 ба түүнээс дээш насны хариуцлагатай хүнийг тооцдог.

Бага сургуулийн хүүхдүүд жижиг биетэй, ялангуяа үзэгдэх орчин муу үед жолооч нарт харахад хэцүү байдаг. Тэд замын хөдөлгөөний дүрмийг уншиж чаддаг боловч дүрмүүд нь юу гэсэн үг болохыг одоо хүртэл сайн ойлгодоггүй. Тэд "аюултай" эсвэл "аюулгүй" гэх мэт ойлголтуудыг ойлгодоггүй. Тэд хийж байгаа зүйлдээ уус ч, эргэн тойрондоо юу болж байгааг мэдэхгүй эсвэл тохиолдсон зүйлээс болж сатаарч, хийж байгаа зүйлээ мартаж болно. Тэднийг зам дээр аюулгүй байдлаа хадгална гэдэгт найдах боломжгүй юм.



Замын хөдөлгөөнтэй ойрхон хаана ч явсан 8 хүртэлх насны хүүхдүүд том хүний гараас хөтөлж явах хэрэгтэй. Том хүн нь авто зам талдаа явах хэрэгтэй. Эх сурвалж: <https://road4us.org/en/>

**8, 9
настай
хүүхэд**

Бага сургуулийн 3, 4-р ангийн хүүхдүүд (8-аас 10 орчим насны)-ийн хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хэрэгтэй ур чадвар, мэдлэг нь дөнгөж хөгжиж эхэлж байдаг. Энэ насанд олон тооны бага насны хүүхдүүд явганаар хөдөлгөөнд оролцож зам тээврийн ослоор нас барж, гэмтдэг байна. Хүүхдүүдийн аюулгүй хэсгээр зам хөндлөн гарах мэдлэг, ур чадвар нэмэгдэж байдаг. Ямар ч үед авто зам эсвэл төмөр замын гармыг эгц хөндлөн гарахдаа Зогс! Хэр! Сөнс! Бод! үйлдлийг хийдэг. Тэд үргэлж суудлын бүсээ зүүх, автомашины арын суудалд сууж байх ёстой талаар суралцаж байдаг.


Хүүхдийг 10 нас хүртэл 12 ба түүнээс дээш насны хариуцлагатай насанд хүрэгч хэзээ ч ямар ч тохиолдолд замын хөдөлгөөний эргэн тойронд маш идэвхтэйгээр харгалзаж байх хэрэгтэй. Замын эргэн тойрон гэдэгт явган хүний зам, автомашины зогсоол, худалдааны төвийн эргэн тойрон, галт тэрэгний ойр хавь, төмөр замын гарам зэрэг

багтана. Хүүхдүүд зам хөндлөн гарах болгондоо насанд хүрэгчийн гараас заавал хөтөлсөн байна. Зам хөндлөн гарах гэдэгт гэрлэн дохиотой гарц, явган хүний гарцууд, төмөр замын гармыг хөндлөн гарах хамаарна.

**10, 11
настай
хүүхэд**

10 насныхаа төрсөн өдрөөс хойш 5, 6-р ангийн олон хүүхдүүд бие даан зорчиж эхлэх болно. Гэсэн хэдий ч зарим нь том болтлоо бэлэн биш байх болно.

Тэд зам хөндлөн гарахдаа аюулгүй газрыг сонгохоо мэддэг, мөн авто зам, төмөр зам хөндлөн гарах болгонд ЗОГС! ХАР! СОНС! БОД! үйлдлийг хийдэг байх ёстой. Тэд үргэлж бүсээ бүсэлж, автомашины арын суудалд суухаа мэддэг байх ёстой. Тэд бусдад суудлын бүсээ бүслэхийг сануулдаг байх ёстой.



Явган зорчигч хүүхэд нь замын хөдөлгөөнөөс хол байх ёстой. Эх сурвалж:
<https://road4us.org/en/>

**12-18
настай
хүүхэд**

Хүүхэд 12 нас хүрэхэд тэдний ихэнхийг нь насанд хүрэгчийн нэгэн адилаар замын хөдөлгөөнд оролцох боломжтой гэж үздэг. Тэд автомашины урд талын зорчигчийн суудалд, суудлын бүс зүүн сууж болно. Мөн тэдний олонх нь өөрөөсөө бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах хариуцлага хүлээж чадна. Гэсэн хэдий ч зарим нь хараахан бэлэн болоогүй эсвэл хариуцлага хүлээх чадваргүй байдаг.

Өсвөр насны үедээ зарим хүүхдүүд найз нарынхаа нөлөөнд хэт орсноор эрсдэлд хүрдэг байна. Ихэнх нь боломжит эрсдэлийг дутуу төоцоолох болон өөрсдийн чадвартаа хэт эрдэх зэргээр өсөлд өрдөг. Тэд автомашин жолоодож эхлэх үедээ туршлага, боловсрол дутуу байдаг.

Бүлэг 3 – Замын хөдөлгөөний аюулгүй байдлын боловсролын талаарх үндсэн зарчмууд

Ерөнхий зарчим

1. Сургуулийн Замын Хөдөлгөөний Аюулгүй Байдлын Бодлого, Замын Цагдаа болон “Сургууль хүртэлх аюулгүй маршрут” хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр бүх сурагчдад дээд зэргийн чанартай замын хөдөлгөөний болон галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын боловсролыг олгоно.

Ангид баримтлах зарчим

2. Хэрэгжиж буй болон хөгжүүлж байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын боловсролыг бүх бага ангийн “Хүн ба Орчин” хичээлийн агуулгын хүрээнд ангийн багшаар дамжуулан хүргэнэ.
3. Багш нар өндөр чанартай, хамгийн сүүлийн үеийн шинэчилсэн эх сурвалжтай (хууль, дүрэм, журам) байх ба сургалтыг үр дүнтэй заах шаардлагатай.
4. Багш нар сурагчдын мэдлэг, чадвар, хандлага, идэвх, зан төлөвийг хөгжүүлэх янз бүрийн идэвхтэй стратеги, амьдрал дээр батлагдсан үр дүнтэй арга замуудыг ашиглана.
5. Багш нар замын бодит нөхцөлд заах дадлагын хичээлээр дамжуулан сурагчдын эрсдэлийн байдлыг тодорхойлох, үнэлэх чадвар дээр анхаарна.

Сургуулийн зарчим

6. Сурагчийн дүрэм, эцэг эхийн аюулгүй зан үйлд зориулсан дүрэмд тусгагдсан, сургуулийн ажилтан бүр нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын үлгэр жишээ загвар болох шаардлагыг онцгойлон заасан Сургуулийн Замын Хөдөлгөөний Аюулгүй Байдлын Бодлогыг хэрэгжүүлэх.
7. Сургуулиуд аюулгүй зан үйлийг дэмжих Суудлын Бүсний Сурагч Цагдаа буюу эцэг эхийнхээ автомашинаар зорчиж байгаа өөрөөсөө бага насны сурагчдад суудлын бүсээ зүүхийг сануулах, хянах, зан үйлийн хэвшлийг мэдээлэх талаар сургалтад сууж, эрхээ авсан 11-р ангийн сурагчдыг ажиллуулах гэх мэт санаачилгуудыг хөгжүүлж, хэрэгжүүлэх.

Эцэг эхийн зарчим

8. Сургууль нь эцэг эхчүүдэд сургуульдаа ирэх, гэртээ харих замдаа тод харагдах аюулгүйн хантааз өмсөхийн ач холбогдлын талаарх ойлголт өгөх үүрэг хүлээнэ. Багш нар сурагчид хантаазаа зөв өмссөн эсэхийг шалгана.

9. Сургуулийн бүсийг Одоор Үнэлэх хөтөлбөр (SR4S) буюу эрсдэлийг үнэлэх арга хэрэгсэл ашиглах, хурдны дээд хязгаар 30 км/цаг байх, хурд сааруулагч тавих, явган хүний зам тавих, ойлгогч толь байрлуулах, тод харагдах явган хүний гарц, тэмдэг, гэрлэн дохио, гудамжны гэрэлтүүлэг, анхааруулах тэмдэг байрлуулах, сургуулиудын эргэн тойронд жолооч нар аюулгүй зорчиход илүү хялбар болгоход зориулан жолоочид зориулсан тэмдэглэгээг байршуулах гэх мэт хэрэгжилтийг дэмжих журмыг гаргах тал дээр хотын удирдлагуудтай хамтран ажиллана.

10. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үйл ажиллагаануудад оролцох, сурагчид, эцэг эхчүүдийг оролцуулах, бүх оролцогч талуудын мэдлэгийг нэмэгдүүлэх.

11. Сургуулийн зарчим нь сургууль дээр ангийн багш нараар заалгасан мэдлэг, мэдээлэл, зан үйлийг хүүхдүүдээ сургуулиас авах, өгөхдөө, амралтын өдрүүдээр, сургуулийн урт хугацааны амралтын үеэр бататгах тал дээр туслах зорилготой эцэг эхчүүдийг мэдээллээр хангах.

Мэдлэг,
дадал,
хандлага

Үр дүнтэй байх үүднээс замын хөдөлгөөний аюулгүй байдлын боловсрол нь мэдлэг, чадвар, хандлага, нийгмийн хэм хэмжээ, хувь хүний зан үйл зэрэгт нөлөөлөхөд чиглэгдсэн байна. Чадвар, хандлагын ач холбогдлыг багтаасан мэдлэг олгох хичээлийн хөтөлбөрийг энэхүү жишээнд дүрслэн харуулав:

Мэдлэг: Суудлын бүс зүүх болон автомашины арын суудалд суух нь яагаад илүү аюулгүйг би мэднэ.

Чадвар: Би суудлын бүсээ зөв бэхлэн, зүүж чадна.

Хандлага: Би автомашин дотор өөрийгөө аюулгүй авч явахыг хүсэж байна.

Нийгмийн хэм хэмжээ: Би эцэг эх, багш нар, миний ах эгч нар, миний үе тэнгийнхэн суудлын бүсээ зүүсэн байхыг хардаг.

Хувь хүний зан үйл Би автомашинаар зорчих болгондоо суудлын бүсээ зүүж, арын суудалд суудаг.

Ангид заалгасан мэдлэг, чадвар, хандлагыг эцэг эх, багш, өөр бусад үлгэр дуурайл үзүүлэх хэн нэгний зуршил болсон аюулгүйн зан үйлтэй хамтатган, хүч хавсарна.

Тасралтгүй давтан бүх сурагчдад хяналт тавих шаардлагатай. Амьдралынхаа туршид суралцах үйл явц нь сурагчдын өөрсдийн амьдралдаа шинэ мэдээлэл авах зуршилтай нь холбогддог, тиймээс тэд сурчихсан байгаа зүйлсээ сайн дураараа түгээж байдаг.



Автомашинаар зорчихдоо бүх зорчигчид суудлын бүсээ зүүсэн байдал. Эх сурвалж: <https://road4us.org/en/>

Бүлэг 4 – Заагдах сэдвүүд

Бага сургууль

1. Замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээний тухай мэдлэгтэй байх, хооронд нь ялгадаг байх, бусдад тайлбарлах чадвартай байх.
2. Замын хөдөлгөөнд оролцохдоо явган хүний гарцын дүрмийн тухай мэдлэгтэй байх, болгоомжтой байх.
3. Тээврийн хэрэгслээр зорчиж байхдаа дүрэм, журмыг дагаж, мөрддөг байх (суудлын бүс бүслэх, бусад нэмэлт хоригуудыг мөрдөх, хогоо хаяхгүй байх, толгой, биеэ цонхоор гаргахгүй байх, бариулаас барьсан байх).

Энэ гарын авлага нь өөр хоорондоо уялдаатай замын хөдөлгөөний аюулгүй байдлын есөн сэдвийг агуулна:

1. Явган зорчигчийн аюулгүй байдал
2. Суудлын автомашинаар зорчигчийн аюулгүй байдал
3. Автобусаар зорчигчийн аюулгүй байдал
4. Мотоциклоор зорчигчийн аюулгүй байдал
5. Сургуульдаа аюулгүй зорчих
6. Галт тэрэгний хөдөлгөөн орчмын аюулгүй байдал
7. Харагдахуйц байх
8. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдгүүд
9. Унадаг дугуйгаар зорчих аюулгүй байдал

Бүлэг 6 – Явган зорчигчийн аюулгүй байдал

Явган зорчигчийн аюулгүй байдлын талаар хүргэх мэдээлэл

ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХДАА АЮУЛГҮЙ ЗАМЫН ХЭСГИЙГ АШИГЛА

ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХ БОЛГОНДОО ЗОГС! ХАР! СОНС! БОД!


ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХДАА НАСАНД ХҮРЭГЧИЙН ГАРААС ХӨТӨЛ

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд 8-10 насны сурагчид дараах зүйлсийг чаддаг болно:

- “Замын хөдөлгөөний орчин” гэсэн нэр томъёоны утгыг болон насанд хүрэгчийн хамт алхах хэрэгтэй газруудыг тайлбарлах
- Амьдардаг газрынхаа болон сургуулийнхаа ойролцоо зам хөндлөн гарах аюулгүй газрыг тодорхойлох, аюулгүйн стратегийн үүднээс насанд хүрэгчийн гараас хөтлөх хэрэгтэйг ухамсарлах
- Насанд хүрэгчийн гарт юм байгаа эсвэл хөтлөх боломжгүй үед өөр бусад ижил төстэй стратегийг тодорхойлох
- Сургуулийнхаа ойролцоо, гэрийнхээ эргэн тойронд байх, хотхондоо, хотдоо байгаа замыг хөндлөн гарах болгондоо яагаад ЗОГС! ХАР! СОНС! БОД! дүрмийг дагах нь чухал болохыг дүрслэн хэлэх. Өөрсдийн болон бусдын аюулгүй байдлыг хамгаалахын тулд дүрмийг мөрдөх үүрэгтэйг хүлээн зөвшөөрөх
- Нийгмийн аюулгүй байдлыг бүрдүүлэхэд тэдний үүрэг, оролцоо байгааг ойлгох
- Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангахад ашигладаг замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээг таних, тайлбарлах

Багш нарт зориулсан суурь мэдээлэл

- Хүүхэд авто замаас хамгийн хол байрлах явган хүний замаар алхах хэрэгтэй.
- Хэрэв тухайн хэсэгт явган хүний зам байхгүй бол авто замын хөдөлгөөнөөс аль болох хол замын хөвөөгөөр алхах нь зүйтэй.
- Арав хүртэл насны хүүхэд зам хөндлөн гарахдаа насанд хүрэгчийн гараас хөтлөх ёстой ба хүүхэд авто замын орчимд байгаа бол хариуцлагатай насанд хүрэгчээр идэвхтэйгээр харгалзуулсан байна. Насанд хүрэгч гэдэгт эцэг эх, гэр бүлийн гишүүн, бусад итгэлтэй хэн нэгэн, 12-оос дээш насны хариуцлагатай насанд хүрэгчийг тооцно.
- Зогсож байгаа тээврийн хэрэгслийн дундуур зам хөндлөн гарч гүйх, зогсож буй тээврийн хэрэгслийн араар эсвэл урдуур гүйх зэрэг нь бага насны явган зорчигчийн осолд өртөх үндсэн шалтгаан байдаг. 8-10 насны олон тооны бага насны явган зорчигчид хариуцлагатай насанд хүрэгчийг харж байхад гэмтдэг.
- Хүүхэд нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж болох талаар мэдээлэл авсан байх. Жишээ нь, хэрэв хүүхэд замын хөдөлгөөнийг харахгүйгээр нэвт гүйх эсвэл ирж буй автомашины хөдөлгөөнийг зогсож буй автомашин халхалснаас хүүхдийн харах боломж хязгаарлагдсан эсвэл тээврийн хэрэгсэл хурдаа багасгаж зогсоох арга хэмжээ авахгүй байх үед явган зорчигч зам хөндлөн гарах нь аюултай.



Хүүхдүүд замын хөдөлгөөнөөс аль болох хол замын хөвөөн дээр явах. Эх сурвалж: <https://road4us.org/en/>


Хичээлийн гол санаа

ТОДОТГОЛ. Хэрэв олон тооны сурагчид сургуульдаа ирэх, гэртээ харихдаа тогтмол автобусаар зорчдог бол автобус хөдөлсний дараа зам хөндлөн гарах явган зорчигчийн аюулгүй байдлын хэсэг нь Бүлэг 8 – Автобусаар зорчигчийн аюулгүй байдал сэдвийн хүрээнд заагдах явган зорчигчийн аюулгүй байдлын хэсэгт хамаарна.

1. Авто замыг аюулгүй хөндлөн гарах

1. Багш сурагчдаас тэдний явдаг явган хүний зам болон хөндлөн гардаг авто замын тухай асууж ярилцан сэдвээ танилцуулна. Тэднийг сургуулиасаа гэр лүүгээ алхаж байх үед зам дээр замын хөдөлгөөнтэй холбоотой юу юу байдаг вэ? Хүүхдүүд аюулгүйгээр зам хөндлөн гарахад туслах хэрэгслүүдийг жагсаан бичнэ (явган хүний зам, явган хүний гарц, гэрлэн дохио, жолоочид зориулсан замын тэмдэг, тэмдэглэл, хаалт, гэрэл ойлгогчтой багана, Цагдаа-Эцэг эх гэх мэт). Багш сурагч нэг бүр эдгээр хэрэгслүүдийн нэр томъёог зөв ашиглаж байгаа эсэх, утгыг мэдэж байгаа эсэхийг шалган баталгаажуулна.
2. Багуудад хуваагдсан сурагчид тус бүрдээ яагаад явган зорчигчид явган зорчигчийн эдгээр хэрэгсэл, тоноглолуудыг ашигладаг байх ёстой шалтгаануудыг жагсаан бичнэ.
3. Багш зам хөндлөн гарах болгондоо баримтлах **ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХ АЮУЛГҮЙН ДАРААЛЛЫГ** танилцуулна:
 - **ЗОГС!** Замын хашлага, замын хөвөөнөөс эсвэл замын хөдөлгөөнөөс буцаж нэг алхам ухарч алхаад зогс
 - **ХАР!** Тээврийн хэрэгслийг харах зорилгоор замын хоёр тал руу толгойгоо эргүүлэн хар
 - **СОНС!** Тээврийн хэрэгсэл ирж байгаа эсэхийг сонсох
 - **БОД!** юу болж байгаа тухай болон хэзээ зам хөндлөн гарах нь аюулгүй байх, насанд хүрэгчийн гараас хөтлөн эгц хөндлөн гарах тухай бод. Зам хөндлөн гарч байхдаа ч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шалгасан хэвээрээ бай.
4. Сурагчид **ЗОГС! ХАР! СОНС! БОД!** таних тэмдгүүдийг хийнэ.
5. Багш сурагчдаас дараах зүйлсийг асууна:

- Яагаад замын хашлагаас 1 алхам хол зогсох нь чухал вэ?
 - Явган хүний зам эсвэл замын хашлага байхгүй бол замаас хэр хол зогсох ёстой вэ?
 - Зам хөндлөн гарахын өмнө яагаад заавал чихэвчээ авах ёстой вэ?
6. Сурагчдыг 2, 2-оор болгоод, дадлага хийх зааварчилгааг өгөөд, сургуулийн явган хүний гарцыг ашиглан **ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХ АЮУЛГҮЙН ДАРААЛЛЫГ** давтуулна. Өөр 2 сурагч тухайн дарааллыг зөв гүйцэтгэж байгаа эсэхийг шалгана (хүүхдүүд нэг алхам хойшоо ухраад хүлээнэ, гар гараасаа барина, толгойгоо замын хоёр тал руу эргүүлнэ гэх мэт), тэгээд хүүхдүүдийг энэхүү дарааллыг зөв хийх хүртэл нь нэмэлт мэдээллийг өгсөөр байна.
7. Сурагчид **Дасгал ажил 1: ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХ ҮЙЛ ЯВЦ**-ийг бөглөнө.
8. Багш зам хөндлөн гарахад аюултай эсвэл осолтой газруудыг танилцуулж, зарим газруудаар хэзээ ч зам хөндлөн гарч болохгүй гэдгийг хүүхдүүдэд хэлж өгнө. Дасгал 2-ын (а)–(е)-д үзүүлсэн зургууд дээр нэг нэгээр нь хэлэлцүүлэг хийж, тухайн газар орны үүнтэй төстэй байрлалуудыг зааж өгнө.



Зам хөндлөн гарах аюултай зан үйл. Эх сурвалж: <https://road4us.org/en/>

9. Сурагчид 2, 2-оороо хамтран **Дасгал ажил-2: Зам хөндлөн гарахад аюултай газруудыг** бөглөнө. Дасгалд байгаа зураг бүрийн нөхцөл байдалд тулгуурласан асуултуудад хариулж, яагаад зам гарахад аюултай байгааг хэлнэ. Хүүхдүүд дараа нь 2-3 зургууд дээр зам хөндлөн гарахад аюулгүй болгох зүйлсийг зурна (жишээ нь, Дасгал 2 (в)–д гэрлэн дохио, явган хүний гарцын тэмдэглэлийг нэмж зурж болно).
10. Сурагчид **Дасгал ажил 3: Хэн Аюулгүй Явган зорчигч вэ? дээр ажиллана:**
11. Интернэт, номын сан зэргээс зураг авч ашиглан, өвлийн цаг агаарын нөхцөлд харагдахуйц байдал, жолоочийн автомашинаа зогсоох чадвар зэрэгт нөлөөлөх байдлын тал дээр хүүхдүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлнэ. Өвлийн улиралд явган зорчигчийн аюулгүй байдал **Бүлэг 12 – Харагдахуйц байдал**-тай холбогдох ёстой.
12. Багш замын хөдөлгөөний нөхцөл өөрчлөгдөх зарчмуудыг танилцуулна. Сурагчид доорх асуудлуудаар хэлэлцэнэ:
- Яагаад зарим замууд бусад замуудтай харьцуулбал цаг үргэлж маш их ачаалалтай байдаг вэ?

- Яагаад зарим замууд тодорхой нэг цагт илүү ачаалалтай, бусад үед ачаалалгүй байдаг вэ?
- Яагаад тодорхой цагуудад замын нэг урсгал нь маш их ачаалалтай, нөгөө нь ачаалалгүй байдаг вэ?
- Эдгээр замаар дурын үед хэрхэн яаж аюулгүй хөндлөн гарах вэ?

13. Сурагчид өөр өөр нөхцөл байдалд зам хөндлөн гарах үеийн аюулгүй байдлын тухай шалгалт өгнө:

а) Замын гэрлэн дохиогоор зам хөндлөн гарах

- Насанд хүрэгчийн гараас хөтлөн зогсох, хэрэв ганцаараа яваа бол насанд хүрэгчтэй ойролцоо зогсох
- Зам хөндлөн гарахаар хүлээж байхдаа замын хашлагаас нэг алхам хойшоо алхаж зогсох
- Товчлуур дарагдаагүй байгаа бол товчлуурыг дарах
- ЯВЖ БОЛОХГҮЙ гэсэн дохио болох улаан гэрэл асаж байвал замын хашлаганы ард үлдэх
- ЯВ гэсэн дохио болох ногоон гэрэл асвал зам хөндлөн гарахад аюулгүй эсэхийг шалгана. Гэрлэн дохио уулзварт байрладаг бол эргэж буй тээврийн хэрэгсэл байгаа эсэхийг шалгана. Зарим жолооч нар үргэлж дүрэм мөрдөөд байдаггүй.
- Эгц хөндлөн, хурдан алхаж гарцаар гар, гарцаар гарч байх явцдаа тээврийн хэрэгсэл замын хоёр талаас ирж байгаа эсэхийг харах, сонсох зорилгоор толгойгоо хоёр тийш нь хөдөлгөсөн хэвээр явах
- Хэрэв зам хөндлөн гарч эхэлсний дараа ЯВЖ БОЛОХГҮЙ гэсэн дохио болох улаан гэрэл асчихвал гарцаар гарах үйлдлээ үргэлжлүүлнэ, гэхдээ гарцаар гарч эхлээгүй бол замын хашлаганы ард зогсож үлдэнэ.

б) Тэмдэглэлтэй гарцаар зам хөндлөн гарах

- Насанд хүрэгчийн гараас хөтлөн зогсох, хэрэв ганцаараа яваа бол насанд хүрэгчтэй ойролцоо зогсох
- **ЗОГС!** Зам хөндлөн гарахаар хүлээж байх зуур замын хашлагаас нэг алхам ухарч алхаад зогс
- **ХАР!** Тээврийн хэрэгслийг харах зорилгоор замын хоёр тал руу толгойгоо эргүүлэн хар
- **СОНС!** Тээврийн хэрэгсэл ирж байгаа эсэхийг сонсох
- **БОД!** юу болж байгаа тухай болон хэзээ зам хөндлөн гарах нь аюулгүй байх, насанд хүрэгчийн гараас хөтлөн гарах тухай бод. Зам хөндлөн гарч байхдаа ч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шалгасан хэвээрээ бай.

с) Явган зорчигчийн гарцын тэмдэглэлгүй замын хэсгээр зам хөндлөн гарах

- Жолооч нар чамайг маш сайн харж болохуйц аюулгүй байрлалыг сонгон зам хөндлөн гар

- Насанд хүрэгчийн гараас хөтлөн зогсох, хэрэв ганцаараа яваа бол насанд хүрэгчтэй ойролцоо зогсох
- **ЗОГС!** Зам хөндлөн гарахаар хүлээж байх зуур замаас эсвэл замын хашлагаас нэг алхам ухарч алхаад зогс
- **ХАР!** Тээврийн хэрэгслийг харах зорилгоор замын хоёр тал руу толгойгоо эргүүлэн хар
- **СОНС!** Тээврийн хэрэгсэл ирж байгаа эсэхийг сонсох
- **БОД!** юу болж байгаа тухай болон хэзээ зам хөндлөн гарах нь аюулгүй байх, насанд хүрэгчийн гараас хөтлөн гарах тухай бод. Зам хөндлөн гарч байхдаа ч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шалгасан хэвээрээ бай.



Зам хөндлөн гарах аюулгүй зан үйл. Эх сурвалж: <https://road4us.org/en/>

14. Сурагчид **Дасгал ажил 4: Явган зорчигчийн аюулгүй байдлын судалгаа-г** бегленэ.

Явган зорчигчийн аюулгүй байдлын талаар хүргэх мэдээлэл
ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХДАА ЗАМЫН АЮУЛГҮЙ ХЭСГИЙГ АШИГЛА
ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХ БОЛГОНДОО ЗОГС! ХАР! СОНС! БОД!
ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХДАА НАСАНД ХҮРЭГЧИЙН ГАРААС ХӨТӨЛ

2. **Зам хөндлөн гарахдаа насанд хүрэгчийн гараас хөтөл**

1. Багш хүүхдүүдээс өөрсдийн аюулгүй байдлаа хангах өөр өөр аргуудын талаар асууж, зам хөндлөн гарахдаа насанд хүрэгчийн гараас хөтлөх тухай тайлбарлан заана. Сурагчид яагаад насанд хүрэгчийн гараас хөтлөх ёстой болон насанд хүрэгч (дунд сургуулийн эсвэл түүнээс дээш насны хүн) гэж хэн болох талаар яриа өрнүүлж, хэлэлцэнэ.
2. Сурагчдад эцэг эхээсээ тэдний хувьд итгэлтэй насанд хүрсэн хүн хэн болохыг асуух даалгавар өгнө. Хүүхдүүд эцэг эхтэйгээ ярилцсаны дараа өөрсдийнх нь хувьд байж болох насанд хүрэгчид (тухайлбал, эцэг эх, эмээ, ахлах сургуульд

- сурдаг төрсөн ах эгч, эцэг эхийнхээ зөвлөсөн өөр бусад таньдаг насанд хүрэгчид гэх мэт)-ийн нэрсийг жагсаан бичнэ, ангидаа жагсаалтын талаар дахин ярилцана.
3. Сурагчид гараас нь хөтлөн зам гарах боломжтой насанд хүрэгчдийг дараах байдлаар ангилна, жишээлбэл, эцэг эх/ гэр бүлийн бусад гишүүд, гэр бүлийн хүмүүс / гэр бүл биш, жолооч / жолооч биш,
 4. Багш сурагчдаас “Хэрэв насанд хүрэгч гартаа тор барьсан байвал та нар гараас нь хөтлөх боломжгүй болно, ийм үед хэрхэн өөрийн аюулгүй байдлаа хангах вэ?” гэж асууна. Сурагчид яриа өрнүүлэн, торноос барих, насанд хүрэгчийн бугалгаас барих, эсвэл хувцаснаас нь барих гэх зэргээр хувилбаруудыг жагсаан бичнэ. Сурагчид зам хөндлөн гарч байхдаа барих аюулгүй байдлын уриа лоозонг хийнэ.
 5. Багш “Хэрэв чамтай хамт насанд хүрэгч яваагүй бол хэрхэн аюулгүй байдлаа хадгалах вэ?” гэж асууна. Багш хүүхдүүдэд тэмдэгтэй, гэрлэн дохиотой гарцаар гарах, эцэг эхийнхээ хамгийн аюулгүй гэж хэлсэн газраар зам хөндлөн гарах, боломжтой бол олноороо зам гарч байгаа насанд хүрэгчдийг даган зам гарах гэх мэт аргууд байгаа талаар заавар, зөвлөгөө өгнө.
 6. Сурагчид насанд хүрэгчийн гараас хөтлөх БОЛОН өөрөөсөө дүү хүүхдийн гараас хөтлөн зам гаргах үүрэгтэй байж болох талаар ойлголт авна. Хүүхдүүд хос хосоороо гараасаа хөтлөн явах дадлага хийнэ, мөн яагаад гараас хөтлөн зам гарах ёстой талаар өөрөөсөө дүү хүүхдэд тайлбарлах талаар сургуулилт хийнэ.
 7. Сурагчид музейд зочилж эсвэл өөрийн амьдардаг газрынхаа хуучны зургуудыг харснаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний орчин хэр их өөрчлөгдчихсөн талаар мэдээлэлтэй болж, яагаад насанд хүрэгчийн гараас хөтөлж зам хөндлөн гарах ёстойгоо ойлгоно. Замын хөдөлгөөн, тээврийн хэрэгсэл хэрхэн өөрчлөгдсөн бэ? Тээврийн Цагдаагийн байцаагч эсвэл өвөө эмээ гэх мэт өөрөөсөө ахмад хүмүүстэй зам хөндлөн гарсан, зам дээр найзтайгаа тоглох тухай, найзынх руугаа очихоор ганцаараа зам хөндлөн гарсан, замын хажуугаар алхсан тухай туршлагаа ярилцана. Сурагчид одоо юу юу өөрчлөгдчихсөн байгаа вэ? Таны хүүхэд насныхтай адилхан хэмжээнд одоо аюулгүй байгаа юу? гэж тэднээс асууна.
 8. Сургууль эцэг эхчүүдийг **Бага Насны Явган Зорчигчийн Аюулгүй Байдлын Мэдээлэл**-ээр хангаж, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хүүхдүүд юу сурчихсан байгаа талаар эцэг эхтэйгээ ярилцаж дэмжлэг үзүүлж ажиллана. Хүүхдүүд, эцэг эхчүүд авсан мэдээллээрээ хоорондоо ярилцаж, гэр бүлээрээ дадлага хийнэ.
 9. Сурагчид Зам хөндлөн гарахдаа Том хүний гараас хөтлөх. Дасгал ажил 5-ыг хийж гүйцэтгэнэ.




Зам хөндлөн аюулгүй гарахад насанд хүрэгчийн гараас хөтлөх. Эх сурвалж: FRED Engineering




Улаанбаатар хот дахь бага насны явган зорчигчид. Эх сурвалж: FRED Engineering

10. Эдгээр гэрэл зургуудыг томруулж хэвлэн сурагчдаасаа асуу:
- Эдгээр зураг дээрх хүүхдүүд хэрхэн аюулгүй байдлаа хангаж байна вэ?
 - Тэд яаж илүү аюулгүй байдлаа хангаж болох вэ?
11. Дараагийн хуудас дээр байгаа зургийг томруулан хэвлэ. Аюулгүй Зам Хөндлөн Гарах Дараалал-ыг тайлбарлах сурагчдыг сонго. Бусад сурагчид тайлбарлаж байгаа хүүхдүүдийг сонсох, шаардлагатай үед засаж өгөх хэрэгтэй гэдгийг хэлж өгнө.
12. Сурагчид **Дасгал ажил 6: Зам хөндлөн гарахад аюулгүй газрууд**. дээр ажиллан юу сурчихсан байгаагаа баталгаажуулна.



Явган хүний гарцын тэмдэглэлтэй хэсгээр зам хөндлөн гарах



Аюулгүй хэсгээр зам хөндлөн гарах

Эх сурвалж: <https://road4us.org/en/>

Бүлэг 7 – Суудлын автомашинаар зорчигчийн аюулгүй байдал

Суудлын автомашинаар зорчигчийн аюулгүй байдал сэдвийн гол мэдээлэл

ҮРГЭЛЖ СУУДЛЫН БҮСЭЭ БҮСЭЛ

АВТОМАШИНЫ АРЫН СУУДАЛД СУУ

ЯВГАН ХҮНИЙ ЗАМ ТАЛ РУУ АВТОМАШИНААС БУУЖ, ЯВГАН ХҮНИЙ ЗАМ

ТАЛААС АВТОМАШИНД СУУ

БҮТЭН БИЕЭРЭЭ СУУДЛЫН АВТОМАШИН ДОТОР БАЙ

АВТОМАШИНААСАА ХЭЗЭЭ Ч ХОГ ХАЯЖ БОЛОХГҮЙ

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд 8-10 насны сурагчид дараах зүйлсийг чаддаг болно:

- суудлын бүсээ хэрхэн зөв бүслэхийг тайлбарлах
- автомашинд зорчих болгондоо суудлын бүсээ зүүх сонголтыг хийх
- 12 нас хүртлээ хүүхдүүдийн хувьд суудлын автомашин дотор суух аюулгүй байрлалыг тодорхойлох

- Хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудыг авч үзэх, орлох хувилбар бүрийг оновчтой дараалуулах
- Яагаад тээврийн хэрэгслийн хажуугаар дугуй унах эсвэл автомашины онгорхой хэсгүүдээр биеийн аль нэг хэсгийг гаргах нь маш аюултай болохыг ойлгох, дүрслэх

Багшид зориулсан суурь мэдээлэл

- Монгол улсын хуулиар жолооч болон зорчигч суудлын бүсээ зүүх үүрэгтэй гэж заасан байдаг. Суудлын бүсийг автомашинаар зорчих болгондоо зүүх ёстой – богинохон зайд зорчсон ч байсан зүүнэ.
- Хүүхдүүд 12 нас хүртлээ арын суудалд зорчих ёстой. Учир нь арын суудал урд талын суудлаас илүү хүүхдийн жижиг биеийг хамгаалах түвшин өндөр байдаг. 12 болон түүнээс доош насны хүүхдийн гэмтэж бэртэх эрсдэл хойд суудалд сууснаас урд суудалд суух үед ойролцоогоор 2 дахин их болдог болохыг судалгаанаас харж болно.⁶
- Суудлын автомашинаар зорчигч 3, 4-р ангийн хүүхэд нь:
 - Цаг үргэлж суудлын бүсээ зүүж байх
 - Явган хүний зам тал руу эсвэл талаас суудлын автомашинаас буух, суух
 - Бүтэн биеэрээ суудлын автомашин дотор байх ёстой.
- Суудлын бүс нь 145 см болон түүнээс дээш өндөртэй нэг хүнд зориулагдан хийгдсэн байдаг. Хоёр хүнийг хамгаалах боломжгүй.
- Бүсний тохиргоо нь доод хэсэгт байрлаж, хүүхдийн ташаан дээгүүр дарж байрласан байх ёстой (гэдсэн дээгүүр биш).
- Бүсний мөрөнд байрлах хэсэг нь цээжин дээгүүр дарж, хүзүү ба мөрний хооронд байх ёстой.
- Сургуулийн зүгээс сургууль, гэрийн хооронд суудлын автомашинаар зорчдог хүүхдүүдийн гэр бүлд суудлын бүсээ зөв зүүх, 12 хүртэл насны хүүхдийг арын суудалд суулгах нь хамгийн аюулгүй талаар зөвлөгөө өгөх хэрэгтэй.



⁶ Австралийн Хүүхдийг ослоос урьдчилан сэргийлэх сан Kidsafe <https://www.kidsafevic.com.au/road-safety/child-restraints/child-restraint-faqs>

- Багийн сурагч бүр нь 3, 2, 1 дугаарт харгалзуулан бичсэн хамгийн гол гурван шалтгаанаа хэлнэ, өөрөөр хэлбэл шалтгаанаа ач холбогдлоор нь дарааллуулна (1 дугаарт хамгийн чухал шалтгаанаа бичнэ).
- Багийн гишүүн нэг бүр шалтгааныг дугаарлан бичсэний дараа багийн ахлагч оноонуудыг хооронд нь нэмж, багийн хувьд хамгийн гол гурван шалтгааныг тодорхойлно.
- Багийн ахлагч эдгээр 3 гол шалтгаан, оноог нь бичнэ.
- Баг тус бүр мэдээллээ багшид өгч, багш өөр хоорондоо ижил төстэй зүйл байгаа эсэхийг суралцагчидтай хэлэлцэн, суудлын бүс зүүхийн үнэ цэнийг тодотгож өгнө.

3. Суудлын бүсний талаарх судалгаа:

- Багш сурагчдад тухайн хичээл дээр судалгаа явуулах гэж байгааг хэлж, үнэнээ бичих нь маш чухал болохыг тайлбарлан ойлгуулна. Хэн нь ч хэн нэгнийхээ хариултыг мэдэхгүй.
- Сурагчдад ягаан, хөх, ногоон өнгийн дөрвөлжин цаас тус бүр 2, 2-ыг өгнө. Тэгээд ягаан (ээж), хөх (аав), ногоон (төрсөн ах эгч) цааснууд дээр ТИЙМ, ҮГҮЙ гэж бичээрэй гэж хэлнэ. Багш самбар дээр гурван багана зураад, багана бүрийн дээд нүдэнд **Ээж, Аав, Төрсөн ах/эгч** гэж бичнэ.
- Багш *Танай ээж суудлын бүсээ үргэлж зүүдэг үү?* гэж асуухад сурагч ягаан цааснаас тохирох хариултыг сонгоно (жишээлбэл. ТИЙМ эсвэл ҮГҮЙ гэж бичсэн цаасыг сонгоно), тэгээд нэрээ бичээгүй цаасаа ангид байх харгалзах саванд хийнэ.
- Багш нэг сурагчийг сонгон авч, нийтдээ хэдэн тийм болон үгүй хариулт байгааг тоолуулаад, самбар дээр зурсан ЭЭЖ гэсэн гарчигтай баганын дор бичүүлнэ.
- Энэ үйлдлийг аав (хөх цаас), төрсөн ах/эгч (ногоон цаас)-ийн хувьд давтан хийнэ.
- Багш сурагчдыг удирдан гэр бүлийнхээ гишүүдэд суудлын автомашинаар зорчих БҮРДЭЭ суудлын бүсээ зүүж байхыг ятгах талаар өгч болох мэдээллийн тухай ярилцана. Ихэнх ослууд гэрийн ойролцоо гардаг байна. Сурагчид бусдад үлгэр дуурайл болох, суудлын автомашинаар зорчих БҮРДЭЭ суудлын бүсээ зүүж байх тэдэнд хэр их чухал болох талаар харилцан ярилцана.
- Судалгааг 3 долоо хоногийн дараа давтан явуулж, үр дүн хэрхэн өөрчлөгдсөнийг харж болно. Сурагчидтай юу яагаад болж байгаа, юу яагаад болохгүй байгаа талаар хэлэлцэж, ангиараа болон гэр бүлээрээ 100% суудлын бүс зүүдэг болох зорилгод хүрэх төлөвлөгөө боловсруулна..

4. Суудлын бүсний сурагч цагдаа хөтөлбөр

- Сурагчид сургуулийн захиралд суудлын автомашинаар илүү аюулгүй зорчиход сурагч, эцэг эхчүүдэд туслах зорилгоор ахлах ангийн сурагчдын багийг бэлтгэх тухай санал хүргүүлнэ. 11-р ангийн хүүхдүүдээс бүрдэх багийг **Суудлын Бүсний Сурагч Цагдаа**-гаар бэлтгэнэ. Тэд сурагчдад, жолооч нарт суудлын бүс зүүхийн ач холбогдлыг сануулна. Гэр бүлтэйгээ хувийн автомашинаар сургуульд ирэх, сургуулиас явах сурагчдыг шалган, суудлын бүсний ашиглалт, арын суудалд суусан байдлын талаар тайлан

мэдээ гаргана. Тэд сургуулийн зан үйлийн байдлыг хянаж, суудлын бүс бүслэлтийн хувь хэмжээний талаар сургуулийн захирлын тавьсан шаардлагын дагуу тайлан гаргана.



Суудлын бүсээ зүүсэн хүүхэд. Эх сурвалж: FRED Engineering

2. Суудлын автомашины арын суудалд суух

1. Багш автомашины урд талын зорчигчийн суудал орчмыг харуулсан гэрэл зураг авна эсвэл олно. Уг зурагт урд талын суудал (хянах самбар, салхины шил) болон жолоочийн суудал, араа (гар тоормос, жолооч) шууд харагдаж байх хэрэгтэй.
2. Багш автомашины ард талын зорчигчийн суудал орчмыг харуулсан гэрэл зураг авна эсвэл олно. Уг зурагт ард талын суудал (урд талын суудлын зөөлөвчтэй дэр) болон суудлын хажуу талууд (арын суудал бүхэлдээ, арын суудал дээрх зорчигч) шууд харагдаж байх хэрэгтэй.
3. Багш сурагчдаас суудлын автомашины хаана голдуу сууж зорчдог болохыг асуугаад, хичээл дээр автомашины суудлын зургуудаа үзүүлээд, хүүхдүүд аль суудалд суух нь илүү аюулгүй гэж үзэж байгааг нь асууна, ингэхдээ суудлын автомашин гэнэт огцом зогсох шаардлагатай болох эсвэл өөр ямар нэгэн автомашин тэднийг мөргөж болох тохиолдлууд дээр яриа өрнүүлнэ.
 - Сурагчдыг 5 эсвэл 6-аар нь багуудад хуваана. Баг бүр ахлагчтай байна. Баг болгонд зургийг нэг бүрчлэн харж, хоорондоо хэлэлцэх 5 минут өгнө.
 - Баг бүр ярилцсан шалтгаануудаа бүгдийг жагсаан бичиж, ангийнхантайгаа хуваалцана.
 - Хэрэв баг ямар нэгэн аюултай “шалтгаан” (жишээ нь, хэрэв хүүхэд урд талын зорчигчийн суудалд суувал жолооч тэдэнтэй ярих, харахад илүү амар байх болно гэх)-ыг үзүүлбэл багш зааварчилгаа өгч, хэлэлцүүлэг өрнүүлнэ (тухайлбал, жолооч замын хөдөлгөөнд анхаарлаа хандуулах ёстой ба хүүхэд суудлын бүсээ зүүж, арын суудалд сууж, аюулгүй байдал хангагдсанаар жолоочийн анхаарал сайн төвлөрөхөд тусалдаг гэх мэт).
 - Арын суудлын аюулгүй байдлын түвшин илүү өндөр ба хүүхдүүд өөрсдийн аюулгүй байдлаа хангах үүднээс суудлын бүсээ зүүж, автомашины арын суудалд суух зэрэг хариуцлагыг хүүхэд бүр хүлээдэг байх шаардлагатай гэдэг дээр голлон ярилцана. Хүүхдүүд 12 нас хүрснээр урд талын зорчигчийн суудал дээр суухад аюулгүй болно.

- Сургуулиуд эцэг эхчүүдийг **Эцэг Эхчүүдэд Зориулсан Бага Насны Зорчигчийн Аюулгүй Байдлын Мэдээлэл** –ээр хангах ба автомашинаар зорчих бүрдээ суудлын бүсээ зүүх, арын суудалд суулгах тал дээр сурагчдад дэмжлэг үзүүлэх тухай эцэг эхчүүдтэй ярилцана. Хүүхэд, эцэг эхчүүд хоорондоо суудлын автомашинаар зорчигчийн аюулгүй байдлын дүрмийн талаар ярилцаж, автомашинаар зорчих болгондоо дадлага хийнэ.

Суудлын автомашинаар зорчигчийн аюулгүй байдал сэдвээр хүргэх гол мэдээлэл

ҮРГЭЛЖ СУУДЛЫН БҮСЭЭ ЗҮҮ

СУУДЛЫН АВТОМАШИНЫ АРЫН СУУДАЛД СУУ

ЯВГАН ХҮНИЙ ЗАМ ТАЛ РУУ ЭСВЭЛ ТАЛААС АВТОМАШИНААС БУУЖ, СУУ

БҮТЭН БИЕЭРЭЭ СУУДЛЫН АВТОМАШИН ДОТОР БАЙ

АВТОМАШИНААСАА ХЭЗЭЭ Ч ХОГ ХАЯЖ БОЛОХГҮЙ

3. Явган хүний зам тал руу эсвэл талаас суудлын автомашинаас бууж, суух

1. Тээврийн хэрэгслээс буухдаа замын хашлага талд байрлах хаалгаар буюу "аюулгүй хаалга"-аар буухын ач холбогдлын талаар сурагчдад хэлж өгнө. Суудлын автомашины хувьд аюулгүй хаалганы наалтыг хийнэ.
2. Хүүхдүүд автомашины арын суудалд өөр зорчигчид байгаа тохиолдолд аюулгүй хаалга руу шилжих шаардлагатайг илэрхийлсэн шалтгаануудыг жагсаан бичнэ.
3. Тээврийн хэрэгсэлд аюулгүй суух, буух зааварчилгааг бага насны зорчигчид өгөх дарааллыг сурагчид бичнэ эсвэл дүрсэлнэ, тэгээд өөрөөсөө дүү сурагчдад тайлбарлана.

4. Бүтэн биеэрээ суудлын автомашин дотор бай

1. Сурагчид суудлын автомашины цонхоор гар эсвэл толгойгоо гаргаснаар юу болж болох талаар тодорхойлон ярилцана. Ийм төрлийн осолд орж болох бүх хүмүүс, тэр хүмүүс юу мэдрэх, эцсийн дүндээ юу тохиолдож болох талаар сурагчид жагсаан бичнэ эсвэл зурна.
2. Сурагчид өөртэй нь чацуу насны хүүхдүүд суудлын автомашинаар зорчиж байхдаа гаргаж болох аюултай үйлдлүүд (жишээлбэл, босож зогсох, суудлын ирмэг дээр суух, цонхоор толгой, гар, сарвуугаа гаргах гэх мэт)-ийн талаар тодорхойлон ярилцана. Багш сурагчдыг удирдан эдгээр зан үйл тус бүр нь яагаад аюултай (тухайлбал, босож зогсох эсвэл суудлын ирмэг дээр сууж зорчих үед суудлын түшлэгт нуруугаараа налж сууж явснаас илүүтэйгээр унах, ямар нэгэн зүйлийг эсвэл хэн нэгнийг мөргөх нь хамаагүй их байдаг гэх мэт) талаар хэлэлцүүлэг өрнүүлнэ. Аюултай зан үйлээс шалтгаалан гарч болох үр дагаврын талаар сурагчид хэлэлцэнэ. Суудлын автомашинд байгаа хүүхэд, жолооч, бусад хүмүүст юу тохиолдож болох талаар хамтатган ярина.
3. Сурагчид өөрсдийн эргэн тойрны хүмүүст, нутаг дэвсгэрт тохиолдох аливаа эрсдэлийг тодорхойлно. Жишээ нь, тээврийн хэрэгслийн хажуугаас барьж явах. Тэд энэ үйлдэл яагаад тэдэнд аюултай талаар хэлэлцэнэ. Хэрэв осол гарвал

өртөж болох бүх хүмүүсийг дүрслэн зураглана – гэр бүл, найз нөхөд, хохирогч, түргэн тусламжийн эмч, сургуулийн ажилтан, спортын баг хамт олон гэх мэтээр ангилна.

5. Автомашинаасаа хэзээ ч хог хаяж болохгүй

1. Сурагчид хүрээлэн буй орчноо хамгаалахын ач холбогдлын талаар ярилцана. Хүрээлэн буй орчиндоо анхаарал тавих арга замуудыг тодорхойлно, үүнд суудлын автомашинаар зорчиж байх үеийн хамгаалалт орно. Хүүхдүүд уриа хийж, суудлын автомашин доторх хогийг аюулгүйгээр цуглуулахад тохиромжтой савыг тодруулна.
2. Сурагчид Хүснэгт -7-г бөглөнө: **Суудлын автомашинаар зорчигчийн аюулгүй байдал нь осол аюул учирч болох нөхцөлүүдийг дүрслэх, үүнийгээ суудлын автомашинаар зорчигчийн аюулгүй байдал, хариуцлагатай холбоход оршино.**
3. Сурагчид ангидаа бүгд гарын үсгээ зурах **Суудлын Автомашинаар Зорчигчийн Аюулгүй Байдлын Тангараг** –ийг хийнэ.

Бүлэг 8 – Автобусаар зорчигчийн аюулгүй байдал

Автобусны аюулгүй байдал сэдвээр хүргэх гол мэдээлэл:

ЗАМААС ЗАЙДУУ ЗОГСОЖ, АВТОБУС ХҮЛЭЭ

БҮТЭН БИЕЭРЭЭ АВТОБУСАН ДОТОР БАЙ

ЖОЛООЧИД СААД УЧРУУЛЖ БОЛОХГҮЙ

АВТОБУСНААС ХЭЗЭЭ Ч ХОГ ХАЯЖ БОЛОХГҮЙ

АВТОБУСЫГ ХӨДӨЛТӨЛ ХҮЛЭЭГЭЭД, АЮУЛГҮЙ ГАЗРААР ЗАМ ХӨНДЛӨН ГАР.

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд 8-10 насны сурагчид дараах зүйлсийг чаддаг болно:

- автобусаар зорчигчийн аюулгүй зан үйлийг дүрслэх
- автобуснаас буусны дараах аюулгүй явган зорчигчийн зан үйлийг дүрслэх
- автобуснаас биеийнхээ аль нэг хэсгийг гаргах нь яагаад үнэхээр аюултайг ойлгох, дүрслэх

Багшид зориулсан суурь мэдээлэл

Автобус хүлээх

Сурагчдыг автобусны буудал дээр аюулгүй байх нөхцөлийг дэмжих үүднээс:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс аль болох хол зайд хүлээх.
- Зам руу өнхөрч орох эсвэл бусад зорчигчдыг гэмтээх хэрэгсэл (жишээлбэл, бөмбөг шидэх) ашиглахгүй эсвэл гүйдэггүй тоглоом тоглох.

Автобусаар зорчих

Автобусны жолооч зорчигчдыг зорьсон газарт нь аюулгүй хүргэх, бусад замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээдэг. Үүний тулд жолооч замын хөдөлгөөнд анхаарлаа төвлөрүүлэх ёстой.

Жолоочид туслах, зорчигчид зорьсон газартаа аюулгүй хүрэх баталгааг бий болгох үүднээс багийн нэг хэсэг мэт байх тал дээр сурагчдыг дэмжих үүднээс:

- Боломжтой бол суудал дээр суух.
- Хэрэв зогсож яваа бол бариул, багана, цагариг зэргээс сайтар атгасан байх.
- Хичээлийн цүнхээ суудлын доогуур байрлуулах эсвэл хэн нэгэн зорчихгүй хэсэгт хөдөлгөөнгүй байрлуулах.
- Бүтэн биеэрээ автобус дотор байх.
- Автобусны цонхоор цаас, хог зэргийг хаях, шидэх нь Монгол улсын хуулийг зөрчиж байгаа үйлдэл гэдгийг санах.
- Жолоочийг үймүүлэхгүй байх.
- Автобусанд байхдаа анхаарал, хүндэтгэл, мэдрэмжээ үзүүлэх.

Автобусаас буух, зам хөндлөн гарах

8-10 насны хүүхдүүд дөнгөж автобусаас буусныхаа дараа хамгийн их эрсдэлд ордог байна. Ихэнх автобуснууд маш хурдан хөдөлдөг, зам маш олон эгнээтэй байдаг. Сурагчдын аюулгүй байдлыг дэмжих үүднээс:

- Автобус бүрэн зогсож, жолооч хаалгыг онгойлгох хүртэл суудал дээрээ сууж байх.
- Өөрийн эд зүйлсээ авч, нэг нэгнээ огт түлхэлгүйгээр удаанаар, болгоомжтойгоор, чимээгүйхэн автобусаас алхаж буух.
- Чихэвчээ авснаар тээврийн хэрэгслийн дууг сонсох боломжтойг ойлгуулах.
- Автобусны урдуур хэзээ ч алхаж болохгүй, учир нь жолооч харахгүй.
- Автобусны ар талаар хэзээ ч алхаж болохгүй, учир нь жолооч харахгүй.
- Автобус холдож явах хүртэл хүлээсний дараа замын аюулгүй хэсгээр зам хөндлөн гарах. Автобус нь том сохор байгууламж (үзэгдэлт хязгаарладаг) тул автобусны ард, урд талын замыг хүүхэд харахгүй, хүүхдийг жолооч харахгүй.
- Тухайн зам нь олон эгнээтэй, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хурд ихтэй, зам дээр хүнд даацын тээврийн хэрэгсэл зогсож байгаа бол сурагчид зөвхөн тэмдэгтэй, гэрлэн дохиотой явган хүний гарцтай хэсгээр зам хөндлөн гарах ёстой.
- Автобусаас буусны дараа зам хөндлөн гарахдаа мөрдөх дүрэм:
 - ХҮЛЭЭ зам хөндлөн гарахад аюулгүй газрыг сонгохынхоо өмнө автобусыг явтал хүлээ.
 - ЗОГС! Замын хашлага эсвэл зорчих хэсгийн захаас хойшоо нэг алхам ухарч алхаад зогс
 - ХАР! Тээврийн хэрэгслийг харах зорилгоор замын хоёр тал руу толгойгоо эргүүлэн хар. Тээврийн хэрэгсэл ирж байна уу эсвэл тээврийн хэрэгсэл зогсож байна уу гэдгийг хар.
 - СОНС! Тээврийн хэрэгсэл ирж байгаа эсэхийг сонс
 - БОД! Зам хөндлөн гарах нь аюулгүй байна уу гэж бод.
 - ХӨТӨЛ Насанд хүрэгчийн гараас хөтөл эсвэл автобусаас цуг буусан насанд хүрэгчдийн хамт зам хөндлөн гар.
 - АЛХ тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шалгасан хэвээрээ зам хөндлөн гарахдаа шулуун алхаж гар.

Хичээлийн агуулга

1. Автобусны эргэн тойрны аюулгүй байдал

- Сурагчид өөрсдийн эргэн тойронд автобусаар зорчдог янз бүрийн замуудын тухай ярилцана. Замын хөдөлгөөн бага уу эсвэл ихэнх замууд тээврийн хэрэгслийн хөдөлгөөн их байдаг уу? Багш автобус хүлээж байх үеийн аюулгүй байдлын талаар жишээн дээр хэлэлцүүлгийг удирдан явуулна.
- Хүүхдүүд Автобусны Зогсоолын Аюулгүй Байдлын талаар зурна.

2. Автобус доторх аюулгүй байдлын зан үйл

1. Сурагчид хоёр, хоёроороо болж Дасгал ажил-8-ыг хайчлан авна: Карт хэлбэрээр хийгдсэн Автобусаар Зорчигчийн тухай Баримт эсвэл Итгэл үнэмшил

Тоглоом тоглоно. Дараа нь сурагчид аль карт нь баримт, аль нь итгэл үнэмшил болох талаар ярилцан, шийдвэр гаргаад, картуудыг хоёр хэсэгт хувааж тавина. Тэгээд хүүхдүүд дахиад нэмж баримтыг харуулсан карт гурвыг, итгэл үнэмшил бүхий карт гурвыг бичнэ. Багш уншсаны дараа дотроос нь сонгон авна, сурагчид тухайн картыг баримт уу эсвэл итгэл үнэмшил үү гэдгийг шийднэ.

2. Багш **Автобусаар зорчих Суурь Мэдээлэл**-ийг шалгана. Сурагчид автобусаар зорчиж байх үеийн аюулгүй байдлыг хангах зан үйлийг тодорхойлон хэлнэ. Сурагчид автобусан дотор тохиолдож болох аюулгүй, аюултай, найрсаг, осолд хүргэх зан байдлыг тодорхойлон, ангилна. Насанд хүрэгчид, хүүхэд автобусны буудал дээр байх үед болон автобусанд зорчих үед аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Автобусаар Зорчигчийн Аюулгүй Байдлын Стандартын Удирдамжийг хөгжүүлнэ.
3. Сурагчид **Дасгал ажил-9 (а): Автобусаар Аюулгүй Зорчигч Байх нь** -ийг бөглөнө.

3. **Автобусыг хөдлөөд явтал хүлээ, тэгээд зам хөндлөн гарахдаа аюулгүй хэсгийг сонгоорой**

1. Багш Суурь мэдээлэлд багтсан **Автобуснаас буух болон зам хөндлөн гарах дараалал** сэдвээр шалгалт авна.
2. Сурагчид **сохор орчны** (үзэгдэлт халхлагдсан орчин) зарчмыг ойлгох ёстой - жолоочид харагддаггүй. Тээврийн хэрэгслийн ард, урд тал, болон чамайг олж харахгүй байгаа эсрэг талаас ирж байгаа тээврийн хэрэгсэлд чи харагдахгүй.



Хүүхдийн харж байгаагаар: нэг ч автомашин алга



Жолоочийн хараанд: хүүхэд бүрэн халхлагдсан⁷

⁷ *Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2.* Австралийн NSW мужийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төв, 1999 он. товхимолоос зургийг хуулбарлав.



*Автобус эсвэл ачааны автомашины урдуур зам хөндлөн гарч байгаа таныг жолооч харж чадахгүй.
Эх сурвалж: <https://road4us.org/en/>*

3. Сурагчид автобуснаас буусныхаа дараа Аюулгүй Зам Хөндлөн Гаргах Дарааллыг багт хуваагдан дадлага хийнэ.
4. Сурагчид Дасгал ажил 9 (б) Автобусанд Аюулгүй Зорчигч байх нь – Чи шийд, сэдэв дээр ажиллана.
5. Сурагчид Дасгал ажил 9 (в) Автобусанд Аюулгүй Зорчигч байх нь – Автобус хөдлөн явсны дараа зам хөндлөн гарах сэдэв дээр ажиллана.

Бүлэг 9 – Мотоциклоор зорчигчийн аюулгүй байдал

Мотоциклоор зорчигчийн аюулгүй байдал сэдвийн гол мэдээлэл:

ҮРГЭЛЖ ХАМГААЛАЛТЫН БЭХЭЛГЭЭТЭЙ МАЛГАЙ ӨМС

БИТҮҮ ХАМГААЛАЛТТАЙ ГУТАЛ, УРТ ХАНЦУЙТАЙ ХҮРЭМ ӨМС

ЖОЛООЧИЙН АРД СУУЖ, ТЭВЭР

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС БУУХ, СУУХДАА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ ТАЛ РУУ БУУЖ, СУУ

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд 8-10 насны сурагчид дараах зүйлсийг чаддаг болно:

- Ангийнхандаа яагаад малгайг өмсөөд, сайтар бэхлэх нь аюулгүй байдлын чухал үйлдэл болохыг тайлбарлах
- Малгайг хэрхэн зөв өмсөх талаар үзүүлэх
- Мотоциклоор зорчихдоо хамгаалах хувцас өмсөх тухай тодорхойлон хэлэх, уг хувцас нь хэрхэн хамгаалдаг талаар тайлбарлах
- Хүүхдүүд яагаад жолоочийн ард суух ёстой болон тээврийн хэрэгслээс буух, суухдаа явган хүний зам тал руу буух, суух ёстой тухай ойлгох, тайлбарлах

Багшид зориулсан суурь мэдээлэл


- Хөдөө орон нутагт мотоцикл нь “хоёр дугуйт гэр бүлийн тээврийн хэрэгсэл” байдлаар ашиглагдах нь түгээмэл бөгөөд 8-10 насны сурагчид мотоциклоор гэр, сургуулийн хооронд зорчиж болно.
- мотоциклын жолооч, зорчигч нар зам тээврийн осолд орох үедээ нас барах, маш хүнд эсвэл насан туршийн гэмтэл авах эрсдэл илүү өндөр байдаг.
- Хүүхэд хатуу гадаргуу, замын хашлага, шон, өөр бусад хөдөлгөөнгүй биетийг толгойгоороо мөргөснөөр толгойдоо болон тархиндаа маш хүнд гэмтэл авах эрсдэлтэй байдаг. 8 болон түүнээс дээш насны хүүхэд бүр мотоциклоор зорчиж байх үедээ нүүрийг нь бүрэн эсвэл хагас бүрхсэн малгайг маш сайн бэхлэн өмсөх ёстой.
- Духаа хамгаалахын тулд малгайг толгойн яг орой дээр байрлуулан, хоёр тал руугаа далий биш, хойшоо нуруу руу унжсан биш байдлаар сайтар бэхлэн бүчилж, өмсөнө. Малгай нь яг хөмсөгний дээд хэсгээс эхлэн хамгаалж байх ёстой. Мөн эрүүн доор сайтар бэхлэгдэн түгжигдсэн байх ёстой. Таны толгой хөдлөх үед малгай хөдлөхөөргүй бэхлэгдсэн байх ёстой.
- Нүүр гэмтэх нь хүүхдийг сэтгэл санааны гутралд хүргэж болох тул нүүрийг бүтнээр хамгаалсан малгайг өмсөхийг зөвлөж байна.
- Насанд хүрэгч нь малгай таарч байгаа эсэхийг болон сайтар бэхлэгдсэн эсэхийг нарийн шалгах ёстой. Малгайн бүч хацрын эсрэг талд хавтгайгаар байрлах ёстой.
- Битүү гутал (шагайг хааж хамгаалсан) нь маш хүнд гэмтлээс хамгаалах үүднээс түрийтэй байна. Зөөлөвчтэй, урт ханцуйтай хамгаалах хувцсыг хүүхэд унах үед арьс зулгарч гэмтэхээс хамгаалах зорилгоор өмсөнө.
- Унах үед хүний автоматаар үзүүлдэг хариу үйлдэл нь нүүрээ хамгаалах зорилгоор гараараа зам гэх мэт зүйл дээр тулдаг бөгөөд энэ нь гартаа маш хүнд

гэмтэл авах анхны шалтгаан болдог. Хөлөө хамгаалаагүй байснаар мотоциклын аюултай эд ангиудтай хөл шүргэлцэн гэмтэх магадлалтай. Битүү биш гутал нь хүүхэд унах, гуталд хүрэх үед сугарах боломжтой.

- Унах үед хамгаалалтгүй арьс гэмтэх аюултай.
- Бага насны эсвэл насанд хүрсэн зорчигч нь жолоочийн ар талд сууж, гараараа тэврэн, хөлөө хөл байрлуулах хэсэгт тавих ёстой.



Мотоциклын зорчигч хамгаалах малгай өмссөн байдал. Эх сурвалж: <https://road4us.org/en/>



Мотоциклын малгайн бүтэц. Эх сурвалж: <https://www.tennandtenn.com/photos/motorcycle-helmet-accident.jpg>

Хичээлийн агуулга

1. Үргэлж хамгаалалтын бэхэлгээтэй малгай өмс

1. Багш дээрх зургийг томруулан, хэвлэж аваад хичээл дээр хүүхдүүдэд үзүүлж, хэрхэн мотоцикл унаж байгаа болон мотоциклоор зорчиж байгаа хүн аюулгүй байдлаар малгайгаа бүчилж бэхлэхийг тайлбарлан өгнө.
2. Сурагчид мотоцикл унаж байгаа бүх хүн малгай өмсөхийг шаарддаг Монголын улсын хуулийн талаар ярилцана. Хүүхдүүд Европ, Солонгос, Вьетнам, Малайз

зэрэг орнуудад мотоциклын хамгаалах малгай өмссөн байгаа сургуулийн хүүхдийн зургийг үзнэ.

3. Сурагчид **Өндөг хамгаалах нь сэдэвтэй дасгал ажил 10** дээр туршилт явуулна:
4. Сурагчдыг 4-6-аар нь баг болгон хуваана. Баг болгонд 5 минут өгч, насанд хүрэгчид болон хүүхдүүд мотоцикл унах болгондоо яагаад малгай өмсөх ёстой болдог шалтгаануудыг жагсаан бичүүлнэ. Сурагч бүрд хамгийн гол гурван шалтгааныг ач холбогдлоор нь 3, 2, 1 гэсэн дарааллаар бичихийг хүснэ (1 нь хамгийн чухал шалтгаан байх ёстой). Багийн гишүүн нэг бүр оноогоо бичсэний дараа багийн ахлагч оноог нэгтгэн нэмж, тухай багийн хувьд хамгийн гол гурван шалтгааныг тодруулан гаргана. Баг энэ гурван гол шалтгаанаа, тэдгээрийн оноог бичнэ. Багууд мэдээллээ өгсний дараа ижил төстэй байдал дээр хэлэлцүүлэг өрнүүлнэ. Хэрэв олон сурагчдын гэр бүл мотоцикл эзэмшдэг бол тэдний гэр бүлийн гишүүд малгай өмсдөг хамгийн гол гурван шалтгааныг илрүүлэх судалгаа явуулж болно.



Хүүхдийн хамгаалах малгай. Эх сурвалж: FRED Engineering

5. Хэрэв сурагчид сургууль руугаа мотоциклоор зорчдог бол мотоциклын хамгаалах малгайг зээлэх ажиллагааг зохион байгуулснаар сурагч нэг бүр малгайг хэрхэн зөв өмсөх ёстой талаар ойлголтыг бүрэн авна. Малгай таарч байгаа эсэхийг шалгахдаа толгой эгц шулуун байрлалтай байхад эрүүний бүчийг сайтар бүчлэн, сурагч бүр толгойгоо урагш хөдөлгөн тайлах гэж оролдоно. Энэ үед тайлагдах ёсгүй. Бусад сурагчид үүнийг хараад малгай зөв бүчлэгдсэн эсэхэд үнэлгээ өгнө.
 6. Сурагчид **Хэрхэн мотоциклын Малгай Бидний Аюулгүй байдлыг хангадаг вэ? Сэдэвтэй дасгал ажил 11-ийг** бөглөнө.
- ## 2. Битүү гутал, урт ханцуйтай хувцас өмс
1. Багт хуваагдсан хүүхдүүд жүрж эсвэл тарвасын нэг талыг барзгар гадаргуу (битум эсвэл бетон) дээр үрж туршина. (Энэ туршилтын үеэр багш маш зузаан хальстай жүрж болон арьс шалбарахаар барзгар биш гадаргууг сонгоно.) Жүрж эсвэл тарвасын хальсыг хүний арьстай харьцуулан үзнэ. Жүржийг таллан зүсэж аваад, нэг талыг нь үрнэ. Жүржийн хальс ижил хэмжээгээр гэмтэж байна уу? мотоцикл унаж байх үед хүний арьсыг хамгаалахын утга учрыг сурагчдаас асуугаарай.
 2. Багш сурагчдыг удирдан яагаад хөл гэмтэх эрсдэл ийм өндөр байдаг талаар хэлэлцэнэ. Гутал сурагч унавал юу болох вэ? Ослын үед хөл ямар нөхцөлд орж

Бүлэг 10 – Сургууль руу аюулгүй зорчих

Сургууль руу аюулгүй зорчих сэдвийн гол мэдээлэл:

СУРГУУЛЬ РУУ ЯВАХ, ИРЭХ ХАМГИЙН АЮУЛГҮЙ МАРШРУТЫГ СОНГО СУРГУУЛИЙН ЦАГДААГИЙН ЗААВАРЧИЛГААГ ДАГА

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд 8-10 насны сурагчид дараах зүйлсийг чаддаг болно:

- Сургуулийнхаа ойролцоо зам хөндлөн гарах болон зам дагуу явахад аюулгүй газрыг тогтоох
- Сургуулийн Цагдаа-Эцэг Эхийн зааварчилгааг мөрдөх нь яагаад аюулгүй чухал үйлдэл вэ гэдгийг ангийнхандаа тайлбарлах
- Хүүхдүүд яагаад сургууль уруугаа хамгийн аюулгүй маршрутыг сонгож явах, мөн явган зорчигчийн аюулгүй байдлын дүрмийг мөрдөх ёстойг ойлгох, тайлбарлах (хэрэв хүүхдүүдийг сургуульдаа дугуйгаар явахыг зөвшөөрдөг бол дугуйн аюулгүй байдлын дүрмийг сахих).

Багш, Сургуулийн захирал, Сургалтын менежер нарт зориулсан суурь мэдээлэл

- 2020 онд Олон Улсын Авто замын Үнэлгээний Хөтөлбөр (iRAP) нь хүүхэд сургуульдаа ирэх, буцахад тулгарч болох эрсдэлийн түвшинг хэмжих, удирдах, харилцахад зориулагдсан үйлдэлд суурилсан программ хангамж болох Сургуулийг Одоор Үнэлэн Зэрэглэх хөтөлбөр (SR4S)-ийг хэрэгжүүлж эхэлсэн.
- SR4S нь авто замын дэд бүтэц, хурдны зохицуулалтын үнэлгээг хялбар хийдэг. Одон үнэлгээний хувьд 1 од нь аюулгүй байдлын түвшин хамгийн бага, 5 од нь дээд зэргийн аюулгүй гэсэн байдлаар үнэлнэ.
- SR4S нь байнгын сайжруулалтыг бий болгох үүднээс хот төлөвлөгч, инженерүүд, БШУЯ болон Сургуулийн удирдлагуудтай хамтран ажиллахыг зөвшөөрдөг. Ингэснээр жолооч нар, эцэг эхчүүд, сургуулиуд хүүхдийн аюулгүй байдлыг сайжруулах боломжтой болдог <https://www.starratingforschools.org/>
- Шонд суурилуулсан ойлгогч гадаргуутай хаяг, самбар гэх мэт энгийн болон өвөрмөц таних тэмдгүүдийг сурагчдын сургуульдаа ирж, буцах зам дагуу байрлуулснаар хүүхдийн аюулгүй байдал хэд дахин нэмэгддэг байна.
- "Сургууль руу явах аюулгүй маршрут" хөтөлбөр нь сурагчдад, сургууль болон орон нутгийн иргэдэд ихээхэн ач тустай болохыг харуулсан.⁸ Хавсралт 2 дээр харуулсан Сургууль руу явах Аюулгүй Маршрут Хөтөлбөрийн Ашиг Тус гэсэн мэдээллийг харна уу. Энэ мэдээллийг сургуулийн хурал эсвэл хэдэн долоо

⁸ Судалгаа: Academic Performance and Attendance. www.saferoutespartnership.org/resources/academic-research/academics

Pabayo, R., et al., 2009 - [Sustained Active Transportation is associated with a favorable body mass index trajectory across the early school years: Findings from the Quebec Longitudinal Study of Child Development birth cohort](https://doi.org/10.1016/j.ssci.2009.11.001), 54, *The more traffic surrounding a child's home, the more likely they are to be overweight or obese*. <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0091743509004393>

хоногийн турш эцэг эхчүүдэд танилцуулсны дараа нэгтгэн “Сургуульдаа аюулгүй явах нь” өдөрлөг дээр танилцуулж болно.

- Дэлхийн Банк саяхан бага, дунд орлоготой улс орнуудын авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дахин авч үзсэн. Монголд хот доторх зам дээр хурдны хязгаар 60 км/цаг байгаа нь дэлхийн хэмжээнд зөвлөж байгаа аюулгүй хурдны хязгаар болох 30 км/цаг утгаас 2 дахин их байна. Дараагийн хуудасны хүснэгтэд харуулсан нас баралтын тоон утга хэрэв хурдны хязгаарыг бууруулбал мөн буурах боломжтой.

ROAD SAFETY COUNTRY PROFILE		Mongolia			East Asia and Pacific (EAP)
SAFE SPEEDS <small>and 1.47.8</small>					
Speeding is a major risk factor for road crash injuries, contributing to both crash risk and crash consequences. A 5% cut in average speed can result in a 20% reduction in the number of fatal road crashes. Effective speed management measures such as establishing and enforcing speed limit laws, traffic calming through roadway design and other measures, and vehicle technology need to be widely implemented.					
MAXIMUM SPEED LIMITS AND ENFORCEMENT					
PILLAR 3	<input checked="" type="checkbox"/>	60 km/h	80 km/h	100 km/h	Manual and Automated
	NATIONAL SPEED LIMIT LAW	URBAN ROADS	RURAL ROADS	MOTORWAYS	SPEED ENFORCEMENT
	Difference with Recommended Safe System Speeds	+ 30 km/h 4 times lower	+ 10 km/h 2 times lower	+ 10 km/h 1 times lower	Potential Decrease in Fatal Road Crashes from Enforcement of Safe System Speed Limits

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Монгол улсын танилцуулга - Аюулгүй хурд ⁹



Бага үнэтэй, үзэгдэлт сайтай хүүхдийн гарцын тэмдэг, шон, зогс тэмдгийг сургуулийн хичээл орох, тарах цагуудад харуулж, шугаман тэмдэглэл тавьж сургуулийн хүүхдийг хамгаалдаг. Эх сурвалж: FRED Engineering

⁹ Дэлхийн банк (2019). Замын хөдөлгөөний аюулгүй байдлын боломж, тулгамдсан асуудлуудын талаархи гарын авлага: Бага, дунд орлоготой орнуудын улс орны танилцуулга. Вашингтон, АНУ, Дэлхийн банк.



Үзэгдэх орчин бягатай газар сургуулийн хүүхдүүд болон насанд хүрсэн явган зорчигчдыг хамгаалахад тохиромжтой өндөр харагдац бүхий тэмдэглэлтэй гарц, тээврийн хэрэгслийн зогс шугамын өргөн тэмдэглэл. Эх сурвалж: FRED Engineering



Хурдны утгыг харуулдаг нарны эрчим хүчээр ажилладаг тэмдэг - хэрэв хурд хязгаараас хэтэрсэн бол "Хурдаа хас" тэмдэг анивчдаг. Эх сурвалж: FRED Engineering

Хичээлийн агуулга

1. Сургуульдаа явах, ирэхдээ хамгийн аюулгүй замыг сонго

1. Багш сургуулийн орчныг энгийн бүдүүвчээр зурна (тухайлбал, Google map-аас татаж авсан) **Сургууль руу Аюулгүй Зорчих Дасгал ажил 12-д** харуулсан шиг байж болно.
 - Сурагчид сургуулийн эргэн тойрны аюултай газруудыг тодотгон хэлнэ (жишээ нь, замын хажуугаар явган хүний зам байхгүй, сурагчид хамгийн ихээр зам хөндлөн гардаг хэсэгт явган зорчигчийн зам гарах гарцын тэмдэг байхгүй, гэрэлтүүлэг байхгүй, явган зорчигчийн зам гарах хэсэгт байрлах тэмдэг нь бүдгэрсэн, жолоочид тод харагдахгүй гэх мэт).
 - Сурагчид газрын зураг дээрх замыг хөндлөн гарах болон алхахад аюулгүй байрлалыг тэмдэглэх тэмдэгтүүдийг ашиглана (жишээ нь, зам хөндлөн гарах тэмдэг, гэрлийн шон гэх мэт).
 - Сурагчид сургуульдаа насанд хүрэгчийн хамт алхаж ирэхдээ ашиглаж болох хамгийн аюулгүй замыг эцэг эхээсээ асууж, **Аюулгүй явган**

зорчигчийн баримтлах дараалал-ын дагуу энэхүү замаар бие даан алхаж дадлага хийснээр юу болсон тухайгаа эцэг эхдээ ярьж өгнө.

2. Сургуулиуд тухайн орон нутгийн хүүхэд, эцэг эхчүүдэд зориулан “Сургууль руу аюулгүй алхах” өдөрлөгийг зохион байгуулна. Сурагч хүүхэд бүр насанд хүрэгчийн хамт алхаж байгаа эсэхийг шалгана.
 3. Сургуулийн захирал, сургалтын менежер нар өвөл эхлэх үед эцэг эхчүүдэд өвлийн цагт аюулгүй зорчих тухай мэдээллийг хүргүүлж, баталгаажуулна. Бүх эцэг эхчүүд цацруулагч бүхий аюулгүйн хантаазыг худалдан авах тал дээр дэмжлэг үзүүлж, хантаазыг хүүхдүүд зөв өмсөж байгаа эсэхийг хянана. Багш нар бага ангийн сурагчид ангиас гарахын өмнө хантаазаа зөв өмссөн эсэхийг шалгана.
 4. Ангиараа Сургуульдаа Аюулгүй Зорчих Дасгал ажил 12 дээр ажиллана.
- 2. Сургуулийн цагдаа-Эцэг эхийг зааварчилгааг дагах**
1. Багш, сургуулийн захирал, Сургуулийн Цагдаа-Эцэг Эхчүүдтэй хамтран хүүхдүүд хэрхэн аюулгүй байдлаа хангаж байгаа, яагаад тэдний зааврыг дагах ёстой талаар сурагчид ойлгосон эсэхийг баталгаажуулна.

Бүлэг 11 – Галт тэрэгний эргэн тойрон дахь аюулгүй байдал

Галт тэрэгний аюулгүй байдал сэдвийн гол мэдээлэл:

ДҮРМЭЭ БИЕЛҮҮЛ, ГАЛТ ТЭРГЭЭР АЮУЛГҮЙ ЗОРЧИГЧ БАЙ
ТӨМӨР ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХДАА ХҮЛЭЭ. ЗОГС!, ХАРИ СОНС! БОДИ
ТӨМӨР ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХДАА ТОМ ХҮНИЙ ГАРААС ХӨТӨЛ


Энэхүү сэдвийг үзэж судалсны үр дүнд 8-10 насны сурагчид дараах зүйлсийг чаддаг болно:

- төмөр замын гарам орчмын биет эд зүйлс, тэдгээрийн зориулалт, үүргийг тодорхойлох, дүрслэх (галт тэрэг, галт тэрэгний тавцан, төмөр зам, гарам, гэрлэн дөхийо гэх мэт)
- галт тэрэгний хөдөлгөөн, төмөр зам орчимд аюулгүй байхад хүүхдүүд юу мэдэх хэрэгтэйг, яагаад эдгээр зүйлсийг хийх ёстойг дүрслэн ярина
- Төмөр замыг аюулгүй хөндлөн гарах үйл явцын ач холбогдлыг ойлгох, дүрслэх

Багш нарт зориулсан суурь мэдээлэл

- Хүүхэд галт тэрэгний осолд өртөхөд гарах үр дагавар нь нас баралт эсвэл насан туршийн гэмтэл байж болно.
- Монгол улсын хаана амьдарч байгаагаас үл хамааран бүх хүүхдүүд галт тэрэгний өртөө, тавцан, өөр өөр түвшинд байрлах гарам, гарц, галт тэрэг, төмөр зам зэрэгтэй харьцах, ойролцоо газраар явах, хөндлөн гарах магадлал байгаа. Тиймээс сурагч бүр галт тэрэгний хөдөлгөөн, төмөр зам орчимд хэрхэн аюулгүй байхыг сурах нь зайлшгүй бөгөөд маш чухал юм.
- Галт тэрэг болон төмөр зам орчимд аюулгүй байх мэдлэг, ур чадварт суралцах нь аюулгүй явган зорчигч болж суралцахад маш чухал байдаг.
- Сурагчид энэ насандаа болон хөгжлийн үе шатандаа өөрсдийн аюулгүй байдалд илүү хариуцлагатай болж эхэлдэг, бие даан зорчих болдог, гэхдээ л галт тэрэгний тавцан, гармаар гарах эсвэл төмөр замыг хөндлөн гарах зэрэгтээ насанд хүрэгчийн хамт явах шаардлагатай.
- Хүүхэд сэтгэн бодох ур чадвараа хөгжүүлж, аюулгүй байхын ач холбогдлыг арай илүү гүн ойлгож эхэлдэг. Тийм хэдий ч хоцорсноос болж гүйх, үе тэнгийн хүүхдээс ирэх дарамт, юм шидэх гэх мэтээр гадуурхах зэрэг гадаад нөлөөлөл байгаа тохиолдолд хүүхдүүд галт тэрэгний орчимд аюултай зан үйл гаргах магадлалтай. Хүч хэрэглэсэн эдгээр нөлөөллүүдийг хэрхэн удирдах дарааллыг тайлбарлана (жишээ нь, харах, сонсох, бодохоо болих, үгүй гэж хэлэх, холдож явах, галт тэрэгний ажилтнаас тусалцаа хүсэх).
- Хүүхдүүдэд бусдын аюулгүй байдлыг хадгалах ур чадвар, өөрсдийн аюулгүй байдлын хувьд бусдад нөлөөлөх хариуцлага хөгжиж эхэлдэг.

- Сургуулийн сурагчид галт тэрэгний тавцангийн ирмэгт ойр, төмөр зам хөндлөн гарч байхдаа болон гармын ойролцоо тоглож байх явцдаа голдуу эрсдэлд ордог. Энэ нь сэтгэлийн хэт хөөрөл, бардамнал (өдөр бүр галт тэргээр зорчдог сурагчид хэзээ галт тэрэг удаан болон хурдан явахыг мэддэг гэдэгтээ хэт итгэдэг гэх мэт) болон танил бус байдал (хотын сурагчид хөдөө орон нутагт зочлох гэх мэт).
- Зарим залуу хүмүүс галт тэрэгний гарам дээр эсвэл гармын ойролцоо эрсдэлтэй үйлдлүүдийг албаар хийдэг. Тэд тухайн үйлдлээс гарах үр дагаврын үр дүнд "надад юу ч тохиолдохгүй" гэсэн хандлагатай байдаг. Тэд өөрсдийгөө аюулд оруулаад зогсохгүй эрсдэлтэй үйлдлийн нөлөөлөлд орсон бага насны хүүхдүүдийг аюулд оруулдаг.
- Хавсралт 1-т байгаа Тайлбар Толь Бичиг дэх нэр томъёог ашиглан сурагчдад төмөр замын аюулгүй байдлын ерөнхий ойлголтуудыг танилцуулна.
- Галт тэрэг хэзээ ч ирж болохыг хатуу ойлгуул.
- 8-10 насны сурагчид нь тэдний гаргаж буй эрсдэлтэй зан үйлдэл нь бусад хүмүүсийг ч бас эрсдэлд оруулна гэдгийг ойлгох хэрэгтэй. Хохирогчийг аврахаар өөрийн амь насаа золиосолж байгаа үйл явдлын эзэн нь хөндлөнгийн гэрч болдог. Ослын ойролцоо эсвэл мөргүүлсэн хүүхдийн ойролцоо байсан галт тэрэгний жолооч, зорчигч, хөндлөнгийн гэрч нар үлдсэн бүх амьдралынхаа туршид сэтгэл санааны маш хүнд шаналлаар зовох магадлалтай байдаг.
- Төмөр зам хөндлөн гарахдаа хүүхдүүд өөрсдийн аюулгүй байдлыг хангаж, насанд хүрэгчийн гараас хөтлөх нь маш чухал ач холбогдолтойг ухамсарлан ойлгох хэрэгтэй. Төмөр замын доогуур эсвэл дээгүүр тавьсан явган зорчигчийн гарам тухайн хэсэгт байгаа бол эдгээр гармыг ашиглан төмөр зам хөндлөн гарахын ач холбогдлыг ойлгох хэрэгтэй.



Pixel perfect компанийн хийсэн дүрс тэмдэг. Эх сурвалж: www.flaticon.com

Хичээлийн агуулга

1. Төмөр замын тавцан болон галт тэрэгний аюулгүй байдал

1. Галт тэргээр зорчиж байсан сурагчдаас төмөр замын тавцан, галт тэрэгний хувьд хүмүүсийн аюулгүй байдлыг хангах үүднээс хийсэн тоног төхөөрөмж, хэрэгслийн талаар жагсаан бичихийг хүсэж, дараа нь эдгээр зүйлсийг самбар дээр бичээрэй. Аюулгүй байдлыг хангах тоноглолуудад тэмдэг, шараар будсан тавцангийн ирмэгийн дагуух шугам, галт тэргийг тавцан дээр хүрэлцэн ирэх хүртэл барьж явах дугуй бариул, галт тэрэгний хаалганы бариул, аюулгүйн түргэн хаагдах түгжээ, анхааруулах сануулга зэрэг орж болно.

- "Шар шугамын ар талд зогс"
- "вагон хоорондын завсрыг сана"

- “Галт тэрэг ирж байна. Хойшоо ухарна уу”
- “Тавцан талын галт тэрэг хөдөлж байна”

2. Сурагчид шинэчилсэн эсвэл нэмэлт хэрэгсэл, тоноглол байгаа тухай хэлэлцэнэ. Эдгээрт шар өнгийн шугамыг мэдрэгчтэй хавтангаар сольсноор хүмүүс тавцангийн ирмэг рүү хэт ойрхон зогсонгуут тэр даруй дохиолол өгөх, харааны бэрхшээлтэй хүмүүс илүү аюулгүйгээр зорчих боломж, нэмэлт анхааруулах санамжууд, дүрэм мөрддөггүй хүмүүст зориулсан торгууль зэргийг дурдаж болно.
3. Сурагчид ямар үйлдэл хийснээр эрсдэлд орох аюултай болох талаар ярилцана – тухайлбал, тавцангийн ирмэгтэй хэтэрхий ойрхон зогсох, гараа эсвэл толгойгоо цонхоор гаргах гэх мэт.
4. Төмөр замын Цагдаа хэрхэн таны аюулгүй байдлыг хангадаг тухай ярилцаарай.

2. Төмөр замын аюулгүй байдал

1. Сурагчдаас хаана галт тэрэг явдаг төмөр замыг харсан талаар асуугаарай (жишээлбэл, тухайн амьдардаг орчинд нь, танай нутагт, зурагтаар, интернэтээр).
2. Сурагчдаас хот, тосгондоо төмөр зам хөндлөн гарч байсан уу гэж асуугаарай. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах хэрэгсэл, зүйлс тэнд байсан уу? (жишээ нь. Хашаа, хашилт, тэмдэг, тэмдэглэл, дуут дохио, анивчдаг гэрэлтэй дохиот хаалт)
3. Хэрэв орон нутагтаа төмөр зам хөндлөн гарч байсан бол ямар ямар хамгаалах хэрэгсэл, зүйлс байсан бэ? гэж сурагчдаас асуугаарай.
4. Сурагчид гармаар гарч байсан газрууддаа харсан зүйлсээ жагсаан бичээд, ангийнхандаа харуулна.
5. Явган зорчигч, төмөр замын ачаа тээврийн сүлжээний гэрэл зургийг цахим орчноос татан авч, хичээл дээр үзүүлнэ.
6. Гэрэл зураг дээрээс юу юу олж харж болох талаар ярилцан, нэр томъёог зөв мэдэж байгаа эсэхийг дахин баталгаажуулна (нэр томъёо нь тайлбар тольд жагсаасан). Харж болох физик биетүүд (бодит хэрэгсэл, эд зүйлс)-ийн талаар ярилцан, дэд бүтэц дээрх ижил төстэй болон ондоо зүйлсийг тэмдэглэн бичихэд нь сурагчдад дэмжлэг үзүүлээрэй. Жишээ нь, зам хөндлөн гарч байгаа зургийг харж байгаа бол дараах байдлаар тайлбарлана:
 - Түвшний ялгаатай гарц гэдэг нь тээврийн хэрэгсэл, явган зорчигч, амьтад төмөр замын дээгүүр гармаар зам хөндлөн гарахыг хэлнэ. Зарим түвшний ялгаатай гармууд зөвхөн явган зорчигчид зориулагдсан байдаг.
 - Зам хөндлөн гарах гарам нь өөр өөр байрлалд өөр өөр хийцтэй байж болох боловч гармуудын олон шинж байдал, зориулалт нь ерөнхийдөө ижил.
 - Эдгээр онцлогууд нь зам хөндлөн гарч байгаа хүнтэй галт тэрэг мөргөлдөхөөс сэргийлж, зогсоох зориулалтаар хийгддэг ба хашлага, хаалт, улаан гэрлэн дохио, хонх, галт тэрэгний дүрст тэмдэг, галт тэрэгний дохио, тэмдэг зэрэг үүнд багтана. Гарам нь дээр дурдсан хэрэгслүүдээс нэг эсвэл хэд хэдэн янзаар байж болно.
 - Хаана, тэдний бодлоор эрсдэлүүд байж болох талаар сурагчдаас асуугаарай, тухайлбал, хэн нэгний гараас хөтлөөгүй бага насны хүүхэд гарам дээгүүр гүйх, явган зорчигч зорчих, гарам дээр бөмбөгөө унагаах,

дугуй унаж буй хүүхэд гарам дээгүүр гарахдаа дугуйнаас унах, суудлын автомашин явган зорчигчийг мөргөх.



Галт тэрэг ба явган зорчигчийн гарам. Эх сурвалж: Монцамэ агентлагийн гэрэл зураг

7. Хүмүүс алдаа гаргаснаас эсвэл тэмдэг, аюулгүй байдлын дүрмийг зөрчсөнөөр галт тэрэгний сүлжээнд аюултай нөхцөл байдал үүсэх тохиолдол олон байдаг:
 - Эргэн тойронд нь зам хөндлөн гарахад тохиромжтой газар байвал тэр газар руу алхаж очоод гарах ёстойг хүүхдүүдэд сануулан хэлээрэй. Жишээ нь, нэг түвшний гарам, эсвэл төмөр замын хоёр чиг маш тод харагдах газар.
8. Сурагчид ТӨМӨР ЗАМЫН ГАРМААР ГАРАХ ҮЙЛ ЯВЦ-ын тухай хэлэлцэн, дадлага хийнэ.
 1. ХҮЛЭЭ! Чихэвчээ аваад, Аюулгүйн шугамын ар талд дуут дохио, гэрэл зэрэг унтарч, хаалт нээгдэх хүртэл хүлээ.
 2. ЗОГС! Төмөр замын гарам дээр байх шугамын ард зогс.
 3. ХАР! Галт тэрэгний хөдөлгөөний хоёр чиглэл рүү хар. Сайтар харах зорилгоор толгойгоо эргүүлэн хар.
 4. СОНСИ! Галт тэрэг ирж байна уу. Чихэвчээ ав.
 5. БОД, “Төмөр зам хөндлөн гарахад аюулгүй юу?”
9. Сурагчид төмөр замын гарам байхгүй хэсгээр ТӨМӨР ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХ ДАРААЛАЛ-ын тухай хэлэлцэн, дадлага хийнэ.
 1. ЗОГС! Төмөр замаас сайтар хойшоо ухар. Чихэвчээ ав.
 2. ХАР! Галт тэрэгний хөдөлгөөний хоёр чиглэл рүү хар. Сайтар харах зорилгоор толгойгоо эргүүлэн хар.
 3. СОНСИ! Галт тэрэг ирж байна уу.
 4. БОД, “Төмөр зам хөндлөн гарахад аюулгүй юу?”
 5. Эгц хөндлөн АЛХаж гар, галт тэрэг ирж буй эсэхийг хянангаа алх
10. Багш сурагчдаас яагаад галт тэрэг эсвэл төмөр замын ойролцоо байхдаа эсвэл гармаар гарч байхдаа чихэвчээ авах, хөдөлгөөнт цахим хэрэгслээ харахаа болих нь чухал болохыг асууна.
11. Сурагчид галт тэрэг нь суудлын автомашин, хүнд даацын тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад хэр том болох, галт тэрэгний жолооч галт тэргийг зогсоход хэр их хүндрэлтэй талаар ярилцана. Галт тэрэг нь хүүхдийг мөргөхөөс сэргийлэн чиглэлээ өөрчлөх боломжгүй.

12. Нэгэнт жолооч ослын тоормос татсан бол зорчигчийн галт тэрэг 250 метр орчим яваад зогсдог. Энэ зайг тоглоомын талбай дээр хэмжиж үзээрэй.
13. Цагт 60 км хурдтай явж байгаа ачааны галт тэргийг зогсооход 1 км орчим зайг туулаад зогсдог. Хөл бөмбөгийн талбайн уртыг мэдэх үү?
14. Өвлийн нөхцөлд, үзэгдэлт хангалтгүй үеийн талаар ярилц. Гармаар аюулгүй гарахад эдгээр нь хэрхэн нөлөөлөх вэ?
15. Сурагчдаас гармаар гарахдаа яагаад дугуйгаа барин алхаж гарах ёстойг асуу. Унадаг дугуйны дугуй нь төмөр замын шилжих зурваст зоогдвол юу болох вэ? Унадаг дугуйны дугуй нь төмөр замын шилжих зурваст зоогдвол эсвэл бөмбөг гарам дээгүүр өнхөрвөл хүүхдүүд юу хийх ёстой вэ?
16. Галт тэрэгний аюулгүй байдлыг хангах үйлдлийн талаар ангидаа бусдад харагдахуйц томоор жагсаалтыг хийж ангидаа тавь.
17. Өөрийн амьдардаг газар болон Монголын аль ч газар байдаг төмөр замын хаалттай, хаалтгүй гарам, галт тэрэгний тавцангийн зургийг харуул (Улаанбаатар дахь болон бусад томоохон хот суурин дахь өртөөг заавал багтаагаарай). Хос хосоороо эсвэл цөөн тоогоороо багт хуваагдаад дараах даалгавар дээр ажиллахыг хүсэх:
 - Анхаарлаа сайтар төвлөрүүлэх шаардлагатай байршлуудыг тодорхойл. ("Би ... анзаарсан")
 - Өөрсдийн аюулгүй байдлаа хангахын тулд юу хийж болохыг тодорхойл. ("Тэгэхээр би ...-х хэрэгтэй")

Жишээ 1. "Миний гатлах ёстой төмөр замын ойролцоо гарам болон нүхэн гарц байхгүйг би анзаарсан. Тэгэхээр би хэзээ ч хамаагүй ирэх магадлалтай галт тэргийг харах, сонсох зорилгоор замын хоёр тал руу толгойгоо эргүүлэх хэрэгтэй гэсэн үг. Төмөр замыг хөндлөн гарахад аюулгүй гэж үзсэн үедээ бүдэрч унахгүйн тулд өмнөх зам руугаа би харах хэрэгтэй."

Жишээ 2. "Гэр рүүгээ дугуй унаж явахдаа төмөр зам хөндлөн гарах шаардлагатай болсныг би олж анзаарсан. Тэнд төмөр замын гарам байдаг. Тэгэхээр би шугамын ард хүлээж, гэрлэн дохио руу харж, дуут дохиог сонсож, дугуйнаасаа буун, төмөр замыг эгц хөндлөн алхаж гарах хэрэгтэй."

18. Галт тэрэг болон төмөр замын талаар хэд хэдэн цуврал асуултыг тавин, ангид яриа өрнүүлнэ. Тухайлбал:
 - 'Төмөр замын ойролцоох аюулгүй байдлыг хэрхэн сайжруулах вэ?'
 - 'Галт тэрэг болон төмөр замыг бидэнд, гэр бүлд маань, бидний эргэн тойрны хүмүүсийн хувьд илүү аюулгүй болгох үүднээс юу юуг бид өөрчлөн хийх вэ?'
 - 'Хэрэв чамд галт тэрэг, төмөр замыг илүү аюулгүй байлгах үүднээс нэг зүйлийг өөрчлөх боломж олдвол юуг өөрчлөх вэ?'



Монгол дахь галт тэрэгний тавцан тал. Эх сурвалж: FRED Engineering

19. Сурагчид Галт тэрэг орчмын аюулгүй байдал Дасгал ажил 13 дээр ажиллана.
20. Сурагчид **Эцэг эхэд Зориулсан Галт Тэрэгний Аюулгүй Байдлын Мэдээлэл** бүхий сурталчилгааны хуудсыг гэр рүүгээ авч яван, галт тэрэг болон төмөр замын ойролцоо байхдаа өөрсдийн аюулгүй байдлыг хангах үүднээс юу юу сурсан тухайгаа эцэг эхтэйгээ ярилцана. Хүүхдүүд болон эцэг эх хоорондоо яриа өрнүүлэн, гэр бүлээрээ дадлага хийнэ.

Бүлэг 12 – Харагдахуйц байх

Харагдахуйц байх сэдвийн гол мэдээлэл:

ӨДРИЙН ЦАГААР ЦАЙВАР ӨНГИЙН ГЭРЭЛ ЦАЦРУУЛДАГ ХУВЦАС, ОРОЙН ЦАГААР ГЭРЭЛ ОЙЛГОДОГ ХУВЦАС ӨМС

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд 8-10 насны сурагчид дараах зүйлсийг чаддаг болно:

- Хүүхдийн аюулгүй байдлыг хангахад яагаад цайвар өнгийн, гэрэл цацруулдаг, гэрэл ойлгодог материал тусалдаг талаар энгийн нэр томъёо ашиглан тайлбарлах

Багшид зориулсан суурь мэдээлэл

- Өвлийн гэрэлтүүлэг муутай нөхцөл, оройн цагаар хүүхэд осолд орх эрсдэл нэмэгддэг, ялангуяа хүүхэд ганцаараа сургуульд ирж, очдог бол өндөр эрсдэлтэй байдаг.
- Олон улс оронд Сургуулийн Замын Хөдөлгөөний Аюулгүй Байдлын Бодлого хэрэгждэг. Энэ бодлогын хүрээнд цэцэрлэгийн болон бага, дунд сургуулийн сурагчид сургуульдаа ирж, очихдоо маш төд харагдах (Hi-Viz) гэрэл цацруулагч цээживч өмсөхийг эцэг эхчүүд дэмжиж ажилладаг. Энэхүү бодлогод сурагчид сургуулийн аялалд явахдаа гэрэл цацруулдаг цээживчийг өмсөх ёстой гэж заасан байдаг.

Өдрийн цагт зориулсан цайвар, гэгээтэй, гэрэл цацруулагч өнгө

- Гэрэл цацруулагч өнгө нь нарны хэт ягаан туяаг шингээж, буцааж ойлгосноор аливаа зүйлсийн өдрийн цагаар харагдах байдлыг нэмэгдүүлж чаддаг онцгой цайвар өнгөнүүд юм. Ийм өнгөнүүдэд шар, улбар шар, ногоон, улаан, ягаан өнгөнүүд орно. Гэрэл цацруулагч өнгө нь өдрийн цагаар сайн харагдахаас гадна манантай, үүлтэй, бүүдгэр, бороотой, цастай өдрүүдэд ч сайн харагддаг.
- Ягаан, шар, улбар шар нь маш сайн харагддаг өнгөнүүд, учир нь байгалийн өнгөнөөс сайн ялгардаг (ногоон, бор, хөх гэх мэт).
- Хөх өнгө нь гэрэл цацруулагч өнгө биш, учир нь гэрлийг сайн ялгаруулдаггүй, хүний нүд хөх өнгийг сайн олж хардаггүй.
- Цаг агаар үүлэрхэг, манантай, бороотой, цастай, бүүдгэр өдрүүдэд, үдээс хойш гэрэлтүүлэг мууддаг. Энэ нь сургуульд ирж, явж байгаа хүүхдийг харахад жолоочид хүндрэл учруулдаг. Гэрэл цацруулдаг аюулгүйн цээживч өмссөнөөр өдрийн цагаар жолооч хүүхдийг олж харахад хялбар болдог.



Цацруулагч хувцас өмссөн байдал. Эх сурвалж: ETSC Key Principles for Traffic Safety and Mobility Education, 2020

Шөнө, оройн цагт зориулсан гэрэл ойлгогч хувцас

- Гэрэл цацруулагч өнгөнүүд нь нарны хэт ягаан туяаг ойлгодог учраас харанхуй үед **ХАРАГДАХГҮЙ**. Тиймээс **шөнө оройн цагаар харагддаг материал шаардлагатай**.
- Ойлгогч материал нь шөнө оройн цагт харагдах байдлыг нэмэгдүүлдэг. Гэрэл ойлгогч материал зүй ёсоороо үйлчлэхийн тулд тухайн орчин харанхуй бөгөөд суудлын автомашины их гэрэл, гудамжны гэрэл гэх мэт гэрэлтүүлгийн эх үүсвэр байх ёстой. Шөнө оройн цагаар ойлгогч гадаргууд автомашины их гэрэл туссанаар гялалзан харагдаж, жолооч явган зорчигчийг харж, хурдаа бууруулан, анхаарлаа нэмэгдүүлнэ.
- Тусгай 'ретро-ойлгогч' материал илүү сайн байдаг ба гэрлийг гэрэл үүсгэгч рүү буцаан ойлгож байхаар хийсэн байдаг. Суудлын автомашин эсвэл хүнд даацын тээврийн хэрэгслийн их гэрэл Ийм төрлийн материал дээр тусах үед гэрэл буцан жолооч руу ойдог, ингэснээр жолооч маш сайн харах нөхцөл бүрддэг.
- Ойлгогч материалын нэг төрлийг **цацруулагч тууз(шилэн шүрт тууз)** гэдэг. Цацруулагч туузаар хийсэн мөнгөлөг-саарал ойлгогч туузыг хувцас дээр хадна. Эдгээр тууз дээр гэрэл тусах үед маш тод цайвар өнгөөр гэрэлтдэг байна.



Шөнийн үзэгдэлтэд зориулсан цацруулагч туузтай гэрэл ойлгодог аюулгүйн хантааз. Эх сурвалж: FRED Engineering

- Өөр бусад төрлийн ойлгогч материалуудыг тусгай өвөрмөц гялалздаг хуванцраар хийсэн байдаг. Замын тэмдэг, унадаг дугуйн цацруулагч зэргийг ийм төрлийн хуванцраар хийж, жолоочид харагдахуйц болгодог.
- Шилэн шүр агуулсан өндөр чанарын будгийг явган хүний гарцыг тэмдэглэхдээ ашигласнаар жолооч нар гарцыг тодоор харах боломж бүрддэг.



Цацруулагч хувцас өмссөн байдал. Эх сурвалж: <https://road4us.org/en/>

Хичээлийн агуулга

1. Сурагчдаас хэзээ жолооч нар хүүхдүүдийг харахад хэцүү байдаг талаар асуугаарай. [Хариултууд: шороон шуурга, тоостой үед, шөнө оройн цагаар, манан, будан, бороо, цас, агаарын бөхирдөлттэй гэх мэт цаг агаарын нөхцөлд, бүрхэг өдөр].
2. 'гэрэл ойлгогч', 'гэрэл цацруулагч' гэсэн шинэ ойлголтуудыг тэдэнд ойлгогдохуйц аргаар тайлбарлан өгч, өдөр, шөнө оройн цагаар гэрэл ойлгуулагч, гэрэл цацруулагч хувцасны үйлчлэх зарчмыг ярьж өгнө.
3. Гэрэл ойлгодог, гэрэл цацруулдаг хувцас өмсдөг хүмүүс, ажилчид, тамирчдын талаар жагсаан бичихийг хүснэ.
4. Сурагчид **Жолоочид Харагдахуйц байх нь Дасгал ажил 14** дээр ажиллана.
5. Сурагчдад замын аюулгүйн хантааз, бугалганы тууз зэрэг нь тээврийн хэрэгслээс хамгаалахгүй гэдгийг сануулан хэлнэ. Аюулгүй байхын тулд явган зорчигчид замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг мөрдөх ёстой: **ЗОГС!, ХАР! СОНС! БОД.**
6. Суурь мэдээллийг ашиглан, багш хэрхэн цацруулагч хэрэгслүүд ажилладаг талаар ярилцана. Багш, сурагчид хамтран **Харагдахуйц байх туршилт. Дасгал ажил 15-г** гүйцэтгэнэ.
7. Багш гэрэл ойлгогч замын тэмдэг, замын "мууран-нүд", гэрэл ойлгогч тэмдгүүд сүйтгэгдсэн байвал сурагчдад юу тохиолдож болох талаар хэлэлцүүлэг хийнэ. Сурагчид бусдыг аюулгүй байлгаж, сайн иргэн байх үүргээ ухамсарладаг.
8. Сурагчид **Шөнө оройн цагаар харагдахуйц байх нь Дасгал ажил 16** дээр ажиллаж явган зорчигчид, дугуйчид аюулгүй байхад туслах хувцас

хэрэглэл(аюулгүйн хантааз, бугуйн тууз), гэрэл, гэрэл ойлгогчийн талаар тайлбарлана.

Бүлэг 13 – Замын хөдөлгөөний аюулгүй байдлын замын тэмдгүүд

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын замын тэмдэг сэдвийн гол мэдээлэл:

АЮУЛГҮЙН ТЭМДГҮҮДИЙГ МӨРДӨХ

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд 8-10 насны сурагчид дараах зүйлсийг чаддаг болно:

- Хүүхдүүд хамгийн их ашигладаг замын тэмдгүүдийг тодорхойлон хэлэх, эдгээр тэмдгүүдийг мөрдсөнөөр аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа талаар тайлбарлах
- Зарим жолооч нар замын тэмдэг, дүрмээ биелүүлдэггүй болохыг ойлгон авах, тиймээс үргэлж ЗОГС! ХАР! СОНС! БОД!

Багш нарт зориулсан суурь мэдээлэл

- 8-10 насны хүүхдүүдийн хувьд өөрсдийн аюулгүй байдлыг хангах болон сургуулийн хүүхэд, бусад явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах үүднээс жолооч нарын дагаж мөрдөж байх ёстой замын тэмдгүүд дээр төвлөрөн ажиллана.
- Сурагчдад жолооч нэг бүр нь замын хөдөлгөөний дүрмийг мөрддөггүй болохыг сануулан хэлнэ. Хүүхдүүд явган зорчигчдод зориулсан замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх ёстой: ЗОГС! ХАР! СОНС! БОД!

Хичээлийн агуулга

Аюулгүй байдлын тэмдгүүдийг мөрд

1. Багш сурагчдаас өдөр бүр ямар ямар замын тэмдгийг сургуульдаа ирж, очихдоо хардаг болохыг асуун, жагсаан бичихийг даалгана. Багш тэднээс жолоочийн, явган зорчигчийн, унадаг дугуйчны аюулгүй байдлыг хангахад туслах өөр ямар ямар тэмдгүүдийг мэддэг талаар нь асууна.
2. Яагаад бидэнд замын хөдөлгөөний дүрэм, замын тэмдэг байдаг вэ? талаар багш хэлэлцүүлгийг удирдана. Тэдний эргэн тойронд байгаа хүн бүр болон Монголд нийтээрээ цаг үргэлж замын тэмдгийг дагаж мөрдөх нь яагаад чухал бэ?
3. Багш замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн замын тэмдгүүдээр шалгалт авч, сурагчдад зориулсан **Замын Хөдөлгөөний Аюулгүй Байдлын Замын Тэмдгүүд Дасгал ажил 17-г** хуулбарлан тараана. Сурагчид замын тэмдгүүд болон түүний тайлбарыг хайчлан авч, тараан тавина. Тэгээд тэмдэг ба тэмдгийн тайлбарыг холбоно.
4. Сурагчид цөөн тоогоор багт хуваагдан, эсвэл ганц ганцаараа **Замын Хөдөлгөөний Аюулгүй Байдлын Замын Тэмдгийн Тойм. Дасгал ажил 18** дээр ажиллана.

Бүлэг 14 – Унадаг дугуйн аюулгүй байдал

Унадаг дугуйн аюулгүй байдал сэдвийн гол мэдээлэл:

АВТО ЗАМААС ХОЛ ГАЗАР ДУГУЙГАА УНАХ

БИТҮҮ ГУТАЛ ӨМС

Энэхүү сэдвийг үзсэний үр дүнд 8-10 насны сурагчид дараах зүйлсийг чаддаг болно:

- Дугуй, скүтер, дугуйт тавцан унахын өмнө бэлтгэх аюулгүй байдлын алхмуудыг жагсаан бичих
- Дугуй, скүтер, дугуйт тавцан унах үед өмсөх хамгаалах хувцас, хэрэглэл, тоноглолыг тодорхойлон хэлэх
- Олон тооны өнгөнүүдээс олж харахад хялбар өнгөнүүдийг сонгох
- Дугуй, скүтер, дугуйт тавцан унахын өмнө бэлтгэх аюулгүй байдлын алхмыг зөвөөр дараалуулах

Багшид зориулсан суурь мэдээлэл

- Хот, аймаг, сум, суурин газар зэрэгт амьдардаг 10 хүртэлх насны хүүхдийн хувьд тээврийн хэрэгслийн нөлөөлөлд өртөхөөргүй, дугуй унах хангалттай том талбайгүй бол дугуй унахыг дэмжихгүй байх нь зүйтэй бөгөөд эцэг эх нь хүүхдийнхээ аюулгүй байдлыг хангаж, дугуй унаж болох газрыг сонгож өгнө.
- Хүүхдүүд 10 нас хүртлээ тээврийн хэрэгсэл болон зорчих хэсгээс хол, замгүй, аюулгүй газарт дугуй, скүтер, дугуйт тавцан зэргийг унах нь зүйтэй.
- Хүүхдүүд 10 нас хүртлээ дөрөөн дээр гишгэн, жийж чадах боловч нөхцөл байдлыг шүүн тунгааж, ямар нэгэн гэнэтийн тохиолдол болоход богино хугацаанд аюулгүй шийдвэр гаргах чадвар нь хөгжөөгүй байдаг. Тэдний замын хөдөлгөөний ойролцоо дугуй унахад шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага хөгжөөгүй байдаг.
- Дугуй, скүтер, дугуйт тавцан унахад таатай, автомашингүй хамгийн аюулгүй газрууд: цэцэрлэгт хүрээлэн, зөвшөөрөгдсөн олон нийтийн талбай, дугуйн зам. Эдгээр газруудад хүүхэд дугуй унахдаа дүрэм нэг бүрийг судалсан байх ёстой.
- 8-10 насны хүүхдүүд зам хөндлөн гарахдаа дугуйнаасаа бууж, ЗОГС! ХАР! СОНС! БОД! гэсэн дарааллыг мөрдөх ёстой.
- Дугуй нь хүүхдэд тохирсон хэмжээтэй эсэхийг шалга. Унадаг дугуйны сандал дээр суугаад бариулаас барьсан үедээ хүүхэд хөлөө бүрэн сунгаж газарт тавихад ямар ч хүндрэлгүй хүрч байх ёстой.
- Хөл гэмтэхээс сэргийлэн битүү гутал өмс. Мөн урт ханцуйтай хувцас нь арьс шалбарахаас хамгаална.
- Гэгээлэг өнгөтэй, цайвар өнгийн хувцас, аюулгүйн хамгаалах хантааз зэрэг нь дугуйчныг олж харахад илүү хялбар болгоно.
- Цементбетон эсвэл өөр бусад авто зам мэтийн хатуу гадаргууд хүүхэд толгойгоо цохивол, мөн багана, шон, эсвэл бусад төрлийн суурин биетүүдийг мөргөвөл

тархиа маш хүндээр гэмтээх аюултай. Унадаг дугуйн малгайг сайтар бэхлэн өмсөх хэрэгтэй.

- Духаа хамгаалах үүднээс хамгаалах малгай нь толгойн хоёр тал уруугаа болон ар тал уруугаа гулсахгүйгээр яг орой дээр байрлаж байхаар тохируулна. Хөмсөг ба хамгаалах малгайны хооронд хоёр хурууны өргөнтэй зайтай, яг духыг таллан байрлаж байх ёстой. Хамгаалах малгайг эрүүний доогуур сайтар бэхлэн өмсөнө. Насанд хүрсэн хүн хамгаалах малгай таарч байгаа эсэхийг шалган, зөв бэхлэн өмссөн байдлыг харна.

Хичээлийн агуулга

1. Авто замаас хол унадаг дугуйгаа унах

1. Сурагчдаасаа өөрсдийнх нь насны хүүхдүүд унадаг дугуй, дугуйт тавцан (scooter), өнхрүүлэгт хавтан (skate) зэргийг унадаг газруудын талаар асуугаарай. Тэд цэцэрлэгт хүрээлэн, олон нийтийн амралтын талбай, дугуйн зам зэрэг дээр дугуйгаа унаж байна уу?
2. Сурагчдаас тэдний насны хүүхдүүд авто зам дээр дугуй унах нь яагаад аюултай вэ? гэж асуугаарай? Яагаад тэдний насны хүүхдүүд шороон шуурга, тоос шороо, мөнхөн будан, өвөл дугуй унах нь аюултай вэ?
3. Багш унадаг дугуйны аюулгүй байдлыг хангах хэрэгслийг жагсаан бичиж, дугуйчин аюулгүй байдлаа хэрхэн хангахыг дүрслэн харуулна. Хэрэв ахлах ангийн сурагч сургууль руугаа дугуйтай ирдэг бол дугуйг нь зээлэн авч аюулгүйн хэрэгслүүдийг үзүүлнэ. Унадаг дугуй бүр нь дараах тоноглолуудаар тоноглогдсон байх ёстой:
 - Дөрөөний шар цацруулагч
 - Дугуйны шар цацруулагч
 - Урд цагаан гэрэл ойлгогч
 - Ар талын улаан ойлгогч
 - Хоёр тоормос
 - Хонх

2. Битүү гутал, хамгаалах хувцас өмс

1. Сурагчдыг багт хуваан, жүржийн эсвэл тарвасын талыг барэгар гадаргууд үр (асфальт эсвэл цемент). (Туршилтын өмнө багш маш зузаан хальстай жүрж болон арьсыг зулгарахааргүй зарим гадаргуунууд дээр туршилтыг явуулсан байх ёстой.) Жүржийн эсвэл тарвасын хальсыг өөрсдийн арьстайгаа харьцуул. Жүржийг нэг нэг ширхгээр нь салган авч, нөгөө талыг нь үр. Жүржийн хальс арьс гэмтэхтэй ижил байна уу? Хүүхдүүд дугуй, өнхрүүлэгт хавтан, дугуйт тавцан зэргийг унаж байхдаа өөрсдийн арьсаа хамгаалах хэрэгслүүд юу байж болох талаар асуугаарай.
2. Багш хүүхдүүдэд хамгаалах хувцасны талаар ярьж өгнө. Ямар ямар хамгаалах хувцас уурхайчид өмсдөг вэ? Ямар хамгаалах хувцас, хэрэгслийг Цагдаа, Цэргийнхэн өмсдөг вэ?
3. Хүүхдүүдийн биеийн аль хэсэг хамгийн их гэмтэж болох вэ? Хүүхэд өөрөө унах үед юу тохиолдож болох талаар харилцан яриа өрнүүлэн, удирдаарай (Хүн бүр

автоматаар нүүрээ хамгаалахын тулд гараараа тулдаг байна). Хүүхэд дугуйгаараа өөрийгөө, замыг, эсвэл өөр ямар нэгэн юмыг мөргөснөөр биеийнхээ аль хэсгийг цохиж болох вэ? (шон, хашаа гэх мэт)? Арьсаа хамгаалах болон аюулгүй дугуйчин байхын тулд хүүхдүүд юу юу өмсөх хэрэгтэй вэ? Хөлөө гэмтээхээс хамгаалах үүднээс түрийтэй, битүү (шагай хамгаалсан), үдсэн гутал өмсөх ёстой. Хэрэв хүүхдүүд унасан тохиолдолд арьсаа хамгаалах үүднээс урт ханцуйтай цамц, хүрэм өмсөх хэрэгтэй.

4. Сурагчид **Аюулгүй Дугуйчин. Дасгал ажил 19** дээр ажиллана.
5. Багш сурагчдаас аль төрлийн тамирчин толгой, тархиа хамгаалах үүднээс хамгаалах малгай өмсдөг вэ? гэж асууна. Багш толгой, тархиа хамгаалахын тулд унадаг дугуйны хамгаалах малгайг заавал өмсөх ёстойг дахин сайтар тайлбарлан хэлнэ.
6. Багш сурагчидтай биеийн хамгийн чухал хэсгүүд болох толгой, тархийг хамгаалах унадаг дугуйн хамгаалах малгайн аюулгүй байдлын үүрэг, онцлогийн талаар ярилцана. Арьс буцаж эдгэж болох боловч толгойн гэмтэл насан туршийнх байж болно.
7. Унадаг дугуйн хамгаалах малгай нь чихийг таглахгүй, агааржуулалтын нүхтэй байдаг. Мотоцикл, унадаг дугуйн хамгаалах малгай олон янз байдаг ба дугуйчид ихэнхдээ бага хурдтайгаар зорчдог учраас хамгаалах малгай өмссөнөөр аюулгүй байдал нь хангагдана.
8. Сурагчид **Унадаг дугуйн хамгаалах малгай нь бидний толгой, тархины аюулгүй байдлыг хангана. Дасгал ажил 20** дээр ажиллана.